2022
№ 04(42)



ШҮҮХИЙН ШИЙДВЭР

ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ

ОНОЛ-АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Хорих ял эдлүүлэх ажиллагаа

ХОРИХ ЯЛ ЭДЛЭХЭЭС ХУГАЦААНЫ ӨМНӨ СУЛЛАХ АЖИЛЛАГААНЫ АЧ ХОЛБОГДОЛ, МӨН ЧАНАР

SIGNIFICANCE AND QUALITY OF EARLY RELEASE



Э.ӨНӨБОЛД

Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын тэнхимийн ахлах багш, хууль зүйн ухааны магистр /LLM/, хошууч
Мэйл хаяг: Unku91@gmail.com

Товч утга: Эрүүгийн хуульд заасан ялын хамгийн хүнд төрөл болох хорих ялын шинжүүд ба хүний эрх, эрх чөлөөг хэрхэн хязгаарлаж байгааг тодорхойлж, хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах асуудал нь эрүүгийн хариуцлагын зорилготой хэрхэн уялдаж байгааг илэрхийлнэ.

Abstract: *It will determine the characteristics of imprisonment, which is the heaviest type of punishment prescribed by the Criminal Code, and how it limits human rights and freedoms, and how the issue of early release before serving a prison sentence is related to the purpose of criminal liability.*

Түлхүүр үг: Эрх зүй, засрал хүмүүжил, хяналт тогтоох, шударга ёс, хүний эрх, шүүхийн шийдвэр, хорих байгууллага, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа.

Key words: *Law, corrections, supervision, justice, human rights, court decisions, prisons, enforcement*

Удиртгал

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд ял оногдуулах, ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах агуулгын хүрээнд тодорхой өөрчлөлтүүд ороод байна. Хорих ялын гүйцэтгэлийн үйл ажиллагаанд зарчмын өөрчлөлтүүд орсон ба үүний хэрээр тухайн салбарын тодорхой асуудлыг гүнзгийрүүлэн судлан үзэх хэрэгцээ бий болгосоор байна .

Жил бүр хорих байгууллагаас хуульд заасан тодорхой үндэслэлээр 200 гаруй хүн суллагдаж байна. Эдгээрийн дийлэнх хувийг хугацаанаас өмнө суллах үндэслэлээр суллагдах явдал эзэлдэг. Хугацаанаас өмнө

суллах нь "хорих байгууллагын оршин суугчид" гэж нэрлэж болох хүний тоог бууруулах, тэдний, нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх, цаашид нийгэмд дасан зохицоход чухал ач холбогдолтой юм.

Шинэчлэн баталсан Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль ялаас чөлөөлөх, суллах үндэслэлд орсон өөрчлөлтүүд хорих ялаас хугацаанаас өмнө суллах асуудалд анхаарал хандуулсан байна. Үүнтэй зэрэгцэн хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан хүмүүс дахин гэмт хэрэг үйлдэх явдал ч мөн их байна. Гэвч үүнээс хамааран хорих ялаас хугацаанаас өмнө суллах институтээс татгалзах үндэслэл байхгүй юм. Гэхдээ энэхүү асуудлыг онолын түвшин, практик хэрэгжилтийг боловсронгуй болгох шаардлага бий.

Иймд хоригдлыг хугацааны өмнө суллах үйл ажиллагааны мөн чанарын нарийн тодорхойлж, уг ажиллагааны онол практикын ач холбогдлыг нэмэгдүүлэх хэрэгтэй.

Үндсэн хэсэг

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах салбарыг анх 1855 онд Францын эрүүгийн хуульд хуульчилсан байдаг.

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах ажиллагаа нь энэрэнгүй ёсны зарчимд үндэслэсэн байдаг бөгөөд ялын зорилго хугацаанаас өмнө хангагдсан тохиолдолд ялыг цаашид эдлүүлэх шаардлагагүй гэсэн агуулгатай юм. Үүнээс гадна хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах явдал нь хорих байгууллагад хэв журам сахиулах болон хоригдлыг засарч хүмүүжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг юм.

Английн нэрт сэтгэгч Р.Оуэн "Төр нь иргэнээ яллахаас татгалзах ёстой. Ял оноож залхаах нь төрийн үүрэг биш, ял гарцаагүй үед аль болох өршөөн уучлах, гэмт хэрэг хийсэн хүн, байгууллага өөрөө өөрсдийгөө яллах ёстой" хэмээн номлож байсан бол Италийн эрдэмтэн Л.Дольчи Оуэний сургаалийг дэмжин "Төр иргэнээ яллан шийтгэж болохгүй харин гэмт хэрэг үйлдэхгүй байх орчныг буй болгох, өрх гэрийн тэргүүн мэт иргэн, харьяатаа засан залруулж байнга асран хамгаалж байх ёстой" гэж номлосон[1].

Харин Платон ялын зорилго нь сэтгэлийн ариусгал бий болгох ба ял хүнийг зовоох тамлах ёсгүй гэж бичсэн байдаг[2].

Тэгвэл Монтеськe, Руссо нарын төлөөлөгчид "Ялын бодлого энэрэнгүй байх ёстой. Ял нь залхаан тарчлаах гэхээсээ илүү дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх, засрал төлөвшилд бодитойгоор нөлөөлөх хөшүүрэг" хэмээн үзэж байв.

---

[1] Р.Оюунбадам нар. Хорих ял эдлүүлэх дэглэмийн эрх зүйн зохицуулалт. УБ., 2005. 6 дахь тал

[2] Грекийн сонгодог үеийн философич, математикч. МЭӨ 428/427 – МЭӨ 348/347

Эдгээр нь ял шийтгэл гарцаагүй байх ёс гэдгийг тодорхойлохын зэрэгцээ түүнийг хүнлэг энэрэнгүй байх ёстой болохыг тодорхойлж байна. Нэг үгээр ял шийтгэл нь гэмт хэрэгтний эсрэг чиглэх бус, харин гэмт хэргийн эсрэг чиглэсэн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргэтэй болохыг харуулж байна.

Хорих ял бол иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, хоригдолд эрхийн хязгаарлалтаар дамжсан цээрлэл амсуулах, дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг гаргуулахгүй байх, нийгмийн дотор байгаа зарим тогтворгүй хүмүүст урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлдэг хамгийн өргөн хэрэглэгддэг төрийн албадлагын онцгой төрөл гэж ойлгож болох бөгөөд хүнд гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай болох нь тогтоогдсон тохиолдолд шүүх тухайн шүүгдэгчийн эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоон, олон нийтээс тусгаарлах замаар тусгай дэглэм бүхий хорих анги, гянданд албадан байлгадаг цээрлэл агуулсан онцгой арга хэмжээ буюу үндсэн ял юм.

Хорих ял бол хүнийг бие махбод, сэтгэл санааны хувьд зовоох, тарчлаах ялын төрөлд хамаарч байна. Хорих ял нь бусад төрлийн ялтай харьцуулан авч үзвэл:

1/ Хоригдол чөлөөтэй зорчин явах эрхээ хязгаарлуулдаг;

2/ Олон нийтээс тодорхой хугацаагаар тусгаарлагддаг;

3/ Харьцангуй удаан хугацаатай;

4/ Төрийн тусгай байгууллага болох хорих ангид хоригддог;

5/ Хоригдол хорих ял эдлэх хугацаандаа нийгэм, хамт олон дотор байж эрх чөлөөт иргэдийн нэгэн адил өөрийн эрх дураар ажиллаж, «хөдөлмөрлөх, амьдрах эрхгүй байдаг;

6/ Нийгэм, төрийн үйл ажиллагаанд Үндсэн хуульд заасан улс төрийн эрхээ эдэлж, оролцох боломжоо алддаг;

7/ Гэр бүл, үр хуухэд, төрөл төрөгсөд, найз нөхдөөсөө хагас тусгаарлагддаг;

8/ Хорих ангийн дэглэм, дотоод журамд захирагдах, тэдгээрийг дагаж мөрдөх шаардлагатай болдог;

9/ Иргэн гэхийн оронд хоригдол гэж дуудуулан нэр төрийн хувьд «ичгэвтэр байдалд орох зэмлэл хүлээдэг;

10/ Ял шийтгүүлэхийн өмнө ажиллаж, сурч байсан хамт олноосоо тусгаарлагддаг;

11/ Эзэмшсэн мэргэжлийн ажлаа болон дур сонирхолтой, хийхийг хүссэн ажил хөдөлмөр эрхлэх эрхгүй;

12/ Удаан хугацаатай хорих ял шийтгүүлсэн хоригдлын эхнэр, нөхөр гэрлэлтээ цуцлуулах нэхэмжлэл шүүхэд гаргахад маргах эрхгүй болдог;

13/ Хорих ангид ял эдэлж байхдаа хийсэн ажлын хөлсөө өөрөө гардан авах, шууд зарцуулах болон өмч хөрөнгө, эд зүйлээ зориулалтаар зарцуулах, чөлөөтэй ашиглах эрхээ тодорхой хэлбэрээр хязгаарлуулдаг байна.[3]

Үүнээс үзвэл хорих ял бол гэмт этгээдэд сэтгэл зүй, бие махбодын хатуу цээрлэлийг мэдрүүлдэг ял шийтгэлийн нэг төрөл юм.

Гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй, эмэгтэй, арван дөрвөн насанд хүрсэн хүнд хорих ялыг оногдуулж болохоор эрүүгийн хуульп тодорхойлсон. Хүний нас, сэтгэхүйн онцлогоос шалтгаалж, бидний дээр дурдсан хорих ял, түүний цээрлэл хүн бүхэнд өөр өөрөөр нөлөөлөх нь гарцаагүй.

Хууль шүүхийн өмнө хүн бүр тэгш эрхтэй хэдий ч тэдний нас, сэтгэл санаа, орчныг харгалзан үзвэл уг зарчим нь хэр хэмжээнд шудрага болохыг ахин нэг эргэн харах хэрэгтэй. Энэ нь хорих ялын онцлог шинжийг харгалзан хорих ялыг оногдуулах хэдий ч уг ял нь ямар хүнд хэрхэн нөлөөлж, үр дүн үзүүлэх нь тодорхойгүй зүйл юм. Хорих ял аливаа хүнд үзүүлэх цээрлэл болоод, түүний эрх, эрх чөлөөний хязгаарлалтын хувьд ялын маш хүнд хэлбэр бөгөөд хүний эрхэнд шууд нөлөөтэй болох нь харагдаж байна.

Хүний эрхийн хувьд хорих ялыг авч үзвэл: Монгол улс ардчилсан нийгмийн үнэт зүйлийг эрхэмлэгч улс болохын хувьд хүний эрхийг нийгмийн бүх шатандаа хангах, хамгаалах нь бидний туйлын зорилго юм. Тэгвэл хүний эрх, цаашлаад хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийн талаар цухас дурдах нь уг судалгааны ажилд нэн шаардлагатай.

Хүний эрх гэдэг хүний хязгааргүй хүсэл юм. Гагцхүү энэ хязгааргүй хүслийг хуулиар хамгаалж, түүгээр хязгаарлаж, хуулиар бэхжүүлдэг. Тиймээс хүний эрхийг хууль тогтоомж, үзэл санаа, тунхаглалаар тогтоож байгаа бус хүний эрх оршиж байгаа учир дээрх хэм хэмжээнүүд нь оршиж байгаа хэрэг.

Харин хорих ял бол ял шийтгэлийн хамгийн хүнд хэлбэр бөгөөд энэ ял шийтгэл нь дээр дурдсан шинжүүдээрээ дамжуулан хүний эрх, эрх чөлөөг хязгаарладаг. Энэхүү хязгаарлал нь хүний хүсэл зоригийг ч үгүй хийж болох ноцтой төрийн албадлагын арга хэмжээ тул хорих ялд хандах хандлага, хорих ял эдлүүлэх ажиллагааны үзэл баримтлал ихээхэн анхааралтай хандах хэрэгтэй.

Тэгвэл хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийн тухай асуудал нь нийгмийн эмзэг асуудлуудын нэг болоод байна.

Хууль зүйн үүднээс бид хорих ялыг тодорхой хугацаагаар гэмт этгээдийн эрх, эрх чөлөөг хязгаарлаж байна гэж харах хэдий ч хорих ял бол хоригдлын эрхийг хязгаарлах урт хугацааныхаа туршид хүний хүсэл

---

[3] Б.Алтангэрэл, Б.Тэмүүлэн. Хорих ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2018. 35 дахь тал.

зориг, ирүүдүйдээ итгэх итгэл, мөрөөдлийг үгүй хийсээр байдаг шинжтэй ял шийтгэлийн хамгийн хүнд хэлбэр.

Тиймээс энэхүү шийтгэлийн хамгийн хүнд хэлбэрийг хэрэглэхдээ хүнийг хүн байлгах тэрхүү үнэт зүйлийг нь үл сэвтээхийг зорих шаардлагатай ба үүнд хорих ялын зорилго орших юм.

Хорих ял эдэлж байгаа этгээд нь бусдаас өөр төрсөн, онцгой махбодь бус харин шударгаар амьдрах арга замаа тодийлөн олж харж чадаагүй, сэтгэл хөдлөлөө барьж чадаагүй, амархан гомддог, амархан баярладаг, эмзэг сэтгэхүйтэй, ертөнцийг үзэх үзэл хязгаарлагдмал зэрэг онцлогтой хүмүүс байх нь элбэг. Чухам ийм хүмүүсийн ухамсар, хүмүүжил, нийгэмшилд нөлөөлөх арга хэмжээнд онцгой анхаарал хандуулах нь чухал. Учир нь хүн бүхэн хорвоод мэндлэхдээ ижил цэгээс эхэлсэн бүгд ижил онцгой биш боловч уг ял нь шийтгэгдэж байгаа хүнийг онцгой болгодог.

Харин торгох, эсхүл нийтэд тустай ажил хийлгэх ял нь ялтныг тодийлөн нийгмийн онцгой субъект болгодоггүй, нийгмийн дунд ажиллах, хөдөлмөрлөх боломж олгодог.

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах гэдгийг тодорхойловол: Монгол Улсын Үндсэн хуульд "эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно" хэмээн тунхагласан байдаг[4].

Ял бол хүний эрх чөлөөг хязгаарладаг. Харин хорих ял нь шууд утгаараа хүний эрх, эрх чөлөөг хорих байгууллагын дэглэм, зэрэглэлээс хамааруулан хязгаарладаг ба ингэхдээ тодорхой хугацааны турш, хэн нэгний хатуу хяналтад үүнийгээ хэрэглэдэг нэгэн албадлагын хэрэгсэл.

Тодорхой хугацаа гэдгийг Монгол Улсын Эрүүгийн хуулиар 6 сараас 20 жил, 25 жил, эсхүл түүнээс ч удаан байхаар томъёолсон байдаг.

Ингэснээр хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах гэдэг нь хуулиар тодорхойлсон дээрх хугацааг бүрэн эдэлж дуусахаас нь өмнө тухайн гэмт этгээдийг хорих ангиас суллах, сул тавих, чөлөөлөх гэсэн ойлголтыг өөртөө агуулах юм.

Нэг үгээр хэлбэл иргэн "Б" нь эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай болох нь тогтоогдож, 4 жил хорих ял шийтгүүлсэн хэдий ч 4 жилийн хугацаа өнгөрөхөөс өмнө буюу 2 жил 6 сарын хугацаанд хорих ялыг эдлээд хорих ангиас суллагдаж болно гэсэн үг.

Энэхүү зохицуулалт нь нийгэмд маш олон хандлага, өгүүлэл дагуулдаг. Тухайлбал иргэд хуулиар тодорхой хугацаагаар ял шийтгүүлсэн хэдий ч түүнийгээ бүрэн эдлэлгүй суллагдаж байгаа нь ял завшиж байгаа хэрэг хэмээн үзэх нь олонтой. Хэн нэгний эрхэнд

---

[4] Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. 1992. №1

халдчихаад түүнийхээ хариуцлагыг хагас дутуу хүлээх нь шудрага бус хэмээдэг.

Гэтэл эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчимд гэмт хэрэг үйлдсэн гэмт буруутай этгээд эрүүгийн хариуцлагаас зайлсхийх, ял завших явдал гарах ёсгүй. Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим нь хуульд заасан журмын дагуу эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх, ял хойшлуулах, тэнсэх зэрэг журмыг хэрэглэхэд саад болохгүй. Зөвхөн хуульд заасан журмын дагуу эрүүгийн хариуцлага ялаас чөлөөлж, хойшлуулж, тэнсэж байгаа нь энэ зарчимтай нийцэж байгаа хэрэг.

Дээрхээс үзвэл хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах нь ямар ач холбогдолтой зүйл юм бэ гэсэн асуулттай тулгарах болно.

Иймд хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах гэдэг нь дараах мөн чанарыг өөртөө агуулж байна.

1. Хэдий гэмт хэрэг үйлдсэн ч гэсэн тухайн этгээдийг хүн хэмээн хүндэтгэж, түүний хүсэл зоригийг мохоолгүй, хамгаалж буй арга хэмжээ юм. Учир нь хорих ял өөрийн онцлог шинжүүдээрээ хүний эрхийг хязгаарлаад зогсохгүй хүний эрхийн үндэс болсон хүсэл зорилгод нь хүртэл нөлөөлдөг. Жишээ нь шүүхээс хорин жилийн ял шийтгүүлсэн этгээд хэзээ дуусах хорин жил гэж бодно. Сэтгэл санааны хүнд цохилтод орно. Улмаар амьдрах хүсэл, хөгжих, хөдөлмөрлөх, хүсэл зоригүй болно. Мөрөөдөлгүй болох аюултай. Чухам үүнийг даван туулахад уг зохицуулалт нь дэмжлэг үзүүлэх, хүний ёсоор амьдрах хүслийг нь тэтгэгч юм.

2. Ялын бодлого энэрэнгүй байх ёстой. Ял нь залхаан тарчлаах гэхээсээ илүү дахин гэмт хэрэг үйлдэхгүй байхад чиглэгдэнэ. Ялын бодлого хүний эрхийг хэдий хязгаарлаж болох ч түүнийг нь боомилсон зүйл байж болохгүй. Учир нь хүний эрх төрөлхийн шинжтэй зүйл бөгөөд тэрхүү төрөлхийн зүйлийг төрөлхийн бус хуулиар боож, тасдаж үл болох бөгөөд харин түүнийг хөхиүлэн дэмжихэд чиглэгдэх ёстой.

3. Гэмт хэрэг үйлдсэн, алдаж эндсэн нэгэнд дахин боломж бий шүү, гэдгийг сануулж буй арга хэмжээ. Хүн гэмт хэрэгт холбогдох, түүнийг үйлдэх шалтгаан нөхцөл нь маш олон учир шалтгаантай тэр бүрийг хуулиар тогтоож зохицуулна гэдэг боломжгүй мэт. Хүн бүр байгалийн дахин давтагдашгүй бүтээл байдаг тул тэр бүгдийг нэг хэмээн үзэж шийдэх нь өрөөсгөл байдаг. Тиймээс алдаж эндсэн хэн бүхнийг ял шийтгэлээр эцэслэх нь хүмүүнлэг ёсны бус төдийгүй, гэмт этгээдэд харамсалтай юм.

Харин хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах зохицуулалт эрх зүйн хувьд дараахь ач холбогдолтой байж болно.

1. Хорих ялыг үр дүнд хүргэх гол ач холбогдолтой. Ял шийтгэл нь тодорхой үр дүнд хүрч, түүний нөлөөний улмаас гэмт хэрэг, гэмт явдал, багасах, гэмт хэргийн талаар үзэх нэг хүний бодол өөрчлөгдөх нь түүний үр дүн юм. Харин хорих ял нь их, бага хугацаатай хэдий ч түүний онцлог

шинжүүд нь хамтдаа гэмт этгээдэд дээрх үр дүнг бий болгодог ялын төрөл. Ингэснээрээ дахиж гэмт хэрэг үйлдэхгүй байх, нийгэмд зөвөөр амьдрах чиг шугамаа олох ач холбогдолтой.

2. Ялын шийтгэлийн мөн чанарыг илэрхийлэх ач холбогдолтой. Бид хуулиар гэмт хэргийг тодорхойлж, түүнд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлдогоос бус хүнийг гэмт хэрэгт тооцож, түүнийг хэрхэн яллаж шийтгэх тухай тодорхойлдоггүй. Иймээс гэмт этгээдийн зан байдал, засрал хүмүүжил, хохирлоо төлсөн байдал, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх нөхцөл, түүний нийгэмшил зэргийг харгалзан хугацааны өмнө сулладаг. Нэг үгээр хэлбэл тухайн этгээдийг гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн тэрхүү нөхцөл арилсан бол түүнийг хорьж шийтгэх нь хүнлэг бус хэрэг төдийгүй, ялын шийтгэлийн мөн чанарыг гуйвуулж буй хэрэг юм.

3. Үндсэн хуульд заасан хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоох ач холбогдолтой. Хүний эрхийг дээдлэж, түүнийгээ тухайн нийгмийнхээ үнэт зүйл хэмээн үзэж, түүнийг хамгаалах, хангах тогтолцоог бий болгохыг үндсэн хуульдаа тунхагласны хувьд манай улс боломжит бүхий нөхцөлд хэнийг ч буруутай, буруугүй, баян, ядуу, нийгмийн гарал, үндэс угсаа, шашин шүтлэг, хэл, ёс, арьс өнгө, хүйсээр үл харгалзан тэднийг хүн хэмээн үзэж хүндэтгэн, түүний эрх, ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрсөн бодлого явуулах учиртай.

Гэтэл практикт хорих ялаас хугацаанаас өмнө суллах ажиллагааны мөн чанарыг нэн түрүүнд авч үзэлгүй хорих анги дахь хамгийн анхаарал татсан, ажиллах шаардлагатай хоригдлуудаас хурдан салах арга хэрэгсэл болгож байгаа нь учир дутагдалтай.

Мөн хорих ялаас хугацаанаас өмнө суллах шаардлага хангасан хоригдолд тавих нийтлэг шаардлагыг хэлбэрийн төдий авч үзэж, холбогдох материалыг бүрдүүлдэг нь энэ ажиллагааны амин чухал зорилгыг үгүйсгэхэд хүрч байна.

Дээрх байдлаар хүний эрх болон ардчилсан нийгмийн үнэт зүйлийн талаас нь чухал ач холбогдолтой зохицуулалт хэмээн үзэж энэхүү өгүүллээр хорих ялаас хугацаанаас өмнө суллах ажиллагааны ач холбогдол, хоригдолд үзүүлэх эерэг нөлөөг тодорхойлохыг зорьлоо.

Дүгнэлт

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах ажиллагааны ач холбогол, мөн чанарын хүрээнд судлан дүгнэхэд:

1. Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь гэмт этгээдийн гэмт зан үйлд нөлөөлөх, тэрхүү зан үйлийн хор уршгийг багасгахад чиглэдэг эрх зүйн тогтолцооны чухал хэсэг юм. Иймд ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах, ял шийтгэлийг хүний эсрэг бус гэмт хэргийн эсрэг чиглэсэн нийгмийн хамгааллын хэрэгсэл байх агуулгыг илрэхийлэгч гол механизм юм.

2. Гэмт этгээдийг хорих, ял эдлүүлэх ажиллагаа нь гэмт хэрэгтний хүн байх язгуур шинжид халдаж болохгүй бөгөөд хүний хүсэл зоригийг

мохоож, зовоон тарчлаах бус харин эсэргээрээ гэмт зан үйл, хандлагад нь нөлөөлж, нийгэмд эргэн нэгдэх хүсэл, тэмүүллийг нь өдөөн баяжуулахад чиглэсэн арга хэмжээ байх хэрэгтэй.

Хорих ялын гол агуулга нь тухайн гэмт этгээдийг нийгмийн тусгаарлан тодорхой хугацаанд засан хүмүүжүүлж, нийгэмшүүлэн, нийгэмд эргэн нэгтгэхэд чиглэсэн арга хэмжээ байх нь чухал.

3. Хорих ялаас хугацааны өмнө суллах ажиллагааны мөн чанарын хувьд хорих хэрэгцээ шаардлага үгүй болсон тэр цагт нь тухайн этгээдийг хорих байгууллагаас суллах нь хорих ялын үр дүнг хамгийн өндөр байлгаж, дахиж гэмт хэрэг үйлдэхгүй байх нөхцөл эрүүгийн хариуцлагын зорилго хангагдах үндэс суурь болно.

Санал

1. Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах ажиллагааны ач холбогдол болон хорих ял эдлүүлэх ажиллагаанд үзүүлэх эерэг нөлөөллийг алба хаагчдад таньж ойлгуулах сургалт явуулах.

2. Хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан хоригдлуудын дунд судалгаа хийж, бусад шалтгаанаар суллагдсан хоригдлуудаас хүмүүжил болон нийгэмд эргэн нэгдэх процесс хэрхэн давуу байгааг судлаж, ач холбогдлыг нь нэмэгдүүлэх арга хэмээ авах.

Ашигласан материалын жагсаалт

1. Монгол улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 1992. №01

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2017. №24

3. Р.Оюунбадам "Хорих ял эдлүүлэх дэглэмийн эрх зүйн зохицуулалт" УБ., 2005 он

4. Б.Алтангэрэл, Б.Тэмүүлэн. "Хорих ял эдлүүлэх ажиллагаа" УБ., 2018 он

5. Грекийн сонгодог үеийн философич, математикч МЭӨ 428/427 – МЭӨ 348/347

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

SAFETY OF BAILIFFS DURING THE COVID-19 PANDEMIC



Э.ЦЭРЭНХАНД

Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, хууль зүйн магистр, ахмад

Мэйл хаяг: E.Tserenkhand@gmail.com

Товч утга: Цар тахлын үед шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулах, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, цар тахлын үеийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн орчныг бий болгох шаардлагыг тодорхойлоход чиглэгдэнэ.

Abstract: *It will be aimed at determining the requirements for organizing decisions of a court are obeyed during the pandemic, ensuring the safety of bailiffs, and creating an appopriate legal environment for implementing decisions of acourt during the pandemic.*

Түлхүүр үгс: Аюулгүй байдал, шүүхийн шийдвэр, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, шийдвэр гүйцэтгэгч, цар тахал, төлбөр гаргуулах ажиллагаа, төлбөр төлөгч

Key words: *Security, judgment, enforcement, bailiff, pandemic, recovery, payer*

Удиртгал

Өнгөрсөн 2019 онд үүсэн бий болсон “Ковид-19” цар тахал нь бидний амьдарч дассан дэлхий ертөнцийг болоод хүний амьдарлын хэвшил, дадлыг тэр чигт нь өөрчилсөн томоохон сургамжит цаг үе байлаа. Хүмүүсийн амьдралын хэв маяг өөрчлөгдсөнтэй холбоотойгоор тэдний харилцаа холбоо, нийгмийн зохион байгуулалт ч тэр чигээрээ өөрчлөгдөх шаардлага хүн төрөлхтний өмнө үүсэн бий болсон юм. Хүний нийгэмд шинэ төрлийн харилцаа бий болохын хэрээр түүнээс үүсэх эрх зүйн үр дагавар бүхий тодорхой төрлийн харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээ даган өөрчлөгддөг жамтай.

Энэ ч агуулгаар хүний аюулгүй байдлын тухай ойлголтод шинэ сорил, шинэ эрсдэл бий болсон гэж үзэж болно.

"Ковид 19" цар тахал хурдацтай тархан, олон улс орон гамшгаас хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлж аюул эрсдэлийг аль болох бага учруулахаар хичээн чармайх болсон нөхцөлд манай улс ч мөн адил нийгмийн амьдралыг хэвийн явуулах, хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, улс орны дотоод хийгээд хүний аюулгүй байдлыг бэхжүүлэх, эрх зүйн оновчтой хувилбарыг сонгон хэрэгжүүлэх шаардлага тулгараад байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн гэж хуульчилсан байдаг[5]. Энэхүү тусгайлсан чиг үүргийнхээ хүрээнд иргэн, захиргаа, зөрчил, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулах, гэмт хэрэг, зөрчил үйлдэх үедээ ашигласан эд зүйл, гэмт хэрэг, зөрчил үйлдэх замаар олж авсан хөрөнгө, орлогыг хураах зэрэг шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шийдвэр гүйцэтгэгч зохион байгуулан ажиллаж байна.

Дээрх ажиллагаа нь ардчилсан нийгмийн үнэт зүйл, үндсэн хуульт байгуулал, нийгмийн шударга ёсыг бэхжүүлэх хамгаалах гол хэрэгсэл болох тул заавал биелэгдэх зүй ёсны шаардлага тулгардаг.

Харин цар тахлын үед шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх шийдвэр гүйцэтгэгчдийн аюулгүй байдлын асуудал нь тулгамдсан асуудлын нэг болсон юм. Учир нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хүрээ хязгаар, шүүхийн шийдвэрт заагдсан тодорхой төрлийн үүргийг гүйцэтгэхэд хүний эрх, эрх чөлөөнд хуульд хязгаарлалт тогтоон, төрийн албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хүмүүстэй зайлшгүй уулзах харилцаж үр дүнд хүрдэг онцлогтой.

Иймд цар тахлын үед шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдалд бий болсон аюул, эрсдэл, тулгамдаж буй асуудлыг нийтэд таниулах, судалгаанд суурилсан шийдвэрлэх саналыг дэвшүүлэх замаар энэ төрлийн харилцааг зохицуулсан эрх зүйн хэмжээг хөгжүүлэх шаардлагатай.

Үндсэн хэсэг

Аюулгүй байдлын шинжлэх ухаан нь байгаль, нийгэм, техникийн шинжлэх ухааны уулзвар дээр бүрэлдэн төлөвшсөн салбар билээ[6]. Энэ агуулгаар аюулгүй байдлын судлагдахуун нь явцуу утгаар бүх хамгийн өргөн хүрээний ойлголт хийгээд хүний амьдрал оршин тогтнохуйд нөлөөлөхүйц бүхий л үзэгдэл, үйл явцыг хамааруулан судладаг билээ.

Хүний эрүүл мэндэд аюултай өвчин эмгэгийг судлах, түүний эсрэг

---

[1] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2017. №24

[6] Ч.Улаанхүү. Аюулгүй байдлын үндэс. УБ., 2016. 15 дахь тал.

тэмцэх арга ухааныг нээсэн эртний шинжлэх ухааны салбарыг эрүүл мэндийн шинжлэх ухаан гэх бөгөөд уг салбар шинжлэх ухааны төрлүүд нь бүхэлдээ өөрийн гэсэн эмнэлэг, биологийн аюулгүй байдлын онолыг бий болгосон юм[7].

Иймд дэлхий нийтэд тулгараад буй онцгой аюул буюу цар тахлын үед төрийн онцгой албаны үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулж, түүнээс ямар эрсдэл алба хаагчдад учирсныг сонирхоё.

Цар тахал гэж /Pandemic буюу цар тахал нь грек хэлний pan-all-бүх, demos-people-хүн гэсэн үгсийн нийлбэр/ бөгөөд тив, улс дамнасан өргөн хэмжээний нутаг дэвсгэрийг хамрах халдварт өвчнийг ерөнхийд нь нэрлэх олон улсын нэршил юм.

Манай улсын хувьд "Ковид 19" цар тахлын нөлөөгөөр бүх нийтийн бэлэн байдлын зэрэг шилжих болсонтой холбоотойгоор шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүн, ач холбогдол буурах, шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдалд эрсдэл учрах зэрэг сөрөг үр дагаварууд ихээхэн бий болсон.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар "...төр нь иргэнийхээ зөрчигдсөн эрх, хөндөгдсөн эрх ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх үүрэгтэй[8]" учраас ямарч тохиолдолд шүүхийн шийдвэрийн бодит биелэлтийг ханган ажиллах нь шийдвэр гүйцэтгэгч бүрийн үүрэг юм. Нэг талаас шийдвэр гүйцэтгэгч нь Монгол Улсын иргэн гэдгийг мөн санах хэрэгтэй.

Шийдвэр гүйцэтгэгч нь хуульд зааснаар "иргэний болон захиргааны хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа", "зөрчлийн хэргийн талаархи болон эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа"-г хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг удирдлага болгон чин шударгаар гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэгч юм. Энэхүү ажиллагаа нь ямар тохиолдолд саадгүй хэрэгжих нөхцөл боломжийг хууль тогтоомжоор бататган бэхжүүлэх ёстой.

Монгол Улсын хэмжээнд иргэний болон эрүүгийн хэргийн, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий 30 орчим нэгж үйл ажиллагаа явуулдаг бөгөөд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг улсын хэмжээнд ойролцоогоор 300 шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлж байна.

Шийдвэр гүйцэтгэгч нь хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд төлбөр төлөгчийн эд хөрөнгө, орлогыг олж тогтоох, эрэн сурвалжлах, хөрөнгийг битүүмжлэх, хураах, орон байранд нэвтрэх, хөрөнгийг албадан худалдан борлуулах гэх мэт тодорхой төрлийн албадлагыг хэрэгжүүлэх замаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг ханган ажиллана.

---

[7] Ч.Улаанхүү. Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал. УБ., 2014. 9 дэх тал.

[8] Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 1992. №01

Нэг үгээр шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагааны байнгын хөдөлгөөн, харилцаанд оршиж үр дүнтэй, бодитой хэрэгждэг ажиллагаа болохыг онцлох хэрэгтэй. Энэ ажиллагаанаас шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдалд, хамгийн өндөр эрсдэл үүсэж байна.

Иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах хүрээнд шуурхай, тасралтгүй, бүрэн бодитой явагдах зарчмыг бодитой биелүүлэхийн тулд эрсдэлт нөхцөлд үүрэг гүйцэтгэх шаардлага тулгардаг нь шийдвэр гүйцэтгэгчийн ажлын онцлог бөгөөд цар тахлын буюу гамшигт нөхцөл бий болох үед тус ажиллагааг хэрхэн гүйцэтгэх талаар эрх зүйн болоод практикын шинэ арга журам, туршлага шаардлагатай байгаа нь тодорхой харагдаж байна.

Дэлхий нийтэд Covid-19 өвчний халдвараар 631 сая хүн өвчилж, 6.5 сая хүн нас барсан[9] тохиолдол өнөөдрийн байдлаар бүртгэгдээд байна. Энэ өвчин Монгол Улсад бүртгэгдсэний улмаас 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Засгийн газрын 178 дугаар тогтоолоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, хатуу хөл хорионы үед шийдвэр гүйцэтгэгч нар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулах шаардлагатай болсон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын "Шинэ төрлийн коронавирус буюу "Ковид-19" өвчнөөс урьдчилан сэргийлэх болон халдварт өвчин гарсан тохиолдолд авах арга хэмжээний ажлын төлөвлөгөө"[10]-г 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр батлан, үйл ажиллагаанд мөрдүүлэн ажилласан. Энэ нь тухайн харилцааг зохицуулсан цорын ганц эх сурвалж болж байв. Уг төлөвлөгөөнд бэлэн байдлын зэргийг "бэлэн байдал" буюу ногоон, "Өндөржүүлсэн" буюу шар, "Бүрэн өндөржүүлсэн" буюу улаан гэсэн 3 төрөлтэй байхаар зохицуулсан бөгөөд "бэлэн байдал" *ногоон дохиогоор* ажиллахад авах арга хэмжээг зохицуулсан. Бэлэн байдлын шар болон улаан зэрэгт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулахгүй байдлаар төлөвлөгдсөн.

Коронавируст халдвар цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан халдвар, хамгааллын дэглэмийг чанд сахиж /иргэний болон захиргааны, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрт нийцүүлэн шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулах талаар дурдаад Үүнд:

- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлаас нэг удаагийн халдвар хамгааллын хэрэгслийг алба хаагч нэг бүрт олгох, түүнийг тогтмол хэрэглэх, сард 2-оос доошгүй удаа өрөө тасалгаанд ариутгал хийх

---

[9] COVID Live - Coronavirus Statistics – Worldometer. https://www.worldometers.info › coronavirus

[10] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын "Шинэ төрлийн коронавирус буюу "covid-19" өвчнөөс урьдчилан сэргийлэх болон халдварт өвчин гарсан тохиолдолд авах арга хэмжээний ажлын төлөвлөгөө" Уб., 2020 он.12 дахь тал.

- Төлбөр төлөгч бусад этгээдийн орон байранд нэвтрэх, хөрөнгө битүүмжлэх хураахдаа халдвар хамгааллын хэрэгслийг тогтмол хэрэглэж, хоорондын зай баримлан ажиллах, Шүүхийн шийдвэрийг үндэслэн орон байр, агуулах, барилга, байшин, чөлөөлөх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 26, 27 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулах,

- Ажлын байранд нэвтэрсэн иргэдийн мэдээллийг бүртгэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны өргөдөл, гомдлыг шуудангаар хүлээн авах

- Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийг бүртгэл хяналтыг аль болох биечлэн ирүүлэхгүй байх, шаардлагатай тохиолдолд халдвар хамгаалал, хариуцлагыг дээшлүүлж, холбогдох хууль тогтоомжид нийцсэн шийдвэрийг гарган мөрдүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тогтоож өгсөн байдаг.

Гэвч энэхүү төлөвлөгөө нь шийдвэр гүйцэтгэгч вирусын сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн хүнтэй хэрхэн ажиллах, корона вирусын халдвар авсан төлбөр төлөгч, ялтан этгээдтэй хэрхэн харилцах, түүнтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаарх эрсдэлт нөхцөлд авах арга хэмжээг тусгаагүй байна. Мөн шийдвэр гүйцэтгэгч халдварт өвчний голомтонд байгаагаа мэдсэн үед авах арга хэмжээний талаар зохицуулалтыг дурдаагүй байна. Энэ нь цар тахлын үед явуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны улмаас алба хаагчид учирч болох эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ болж чадаагүй.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлөвлөгөөгөөр хязгаарлах боломжгүй бөгөөд цар тахлын үеийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журам байхгүйгээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулаагүй нь түүний бодит биелэлтэд сөргөөр нөлөөлсөн.

Үүнтэй холбоотойгоор 2021 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт нь өмнөх оноос 30 хувиар буурсан үзүүлэлттэй байна[11]. Ингэснээр иргэдийн зүгээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гаргах гомдлын тоо өмнөх өнөөс 17 хувиар өссөн нь тус ажиллагааны хэвийн байдал алдагдсаныг гэрчилж байна.

Цар тахлын үед байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэхдээ гэнэтийн нөхцөлд байдалд холбогдуулан бий болгосон төлөвлөгөөгөөр бус, бие даасан эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах шаардлагатай болохыг илэрхийлж байна.

Эдгээр нь цар тахалтай холбоотойгоор тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн хэдий ч байгууллагын үйл ажиллагаа доголдож, хуулиар

---

[11] Б.Батмөнх. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны удирдлага зохион байгуулалт магистрын зэрэг горилсон судалгааны ажил. УБ., 2022. 18 дахь тал

хүлээсэн чиг үүргээ биелүүлэхэд ихээхэн хүндрэл учирсан нь байгууллагын аюулгүй байдлын асуудал мөн хөндөгдөж байсныг илтгэж байна.

Харин цар тахлын үеийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үед алба хаагч буюу шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдал хэрхэн хангагдаж байсныг тодорхойльё.

Судалгаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газрын 39 шийдвэр гүйцэтгэгч оролцсон бөгөөд судалгааны асуулгад дараах байдлаар хариулт өгсөн.

"Судалгаанд оролцогчдын 81,6 хувь нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулдаг бол 18,4 хувь нь хорихоос өөр төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулдаг шийдвэр гүйцэтгэгч нар байна. Цар тахлын үеийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үед ажиллах арга зүйн зөвлөгөөг шийдвэр гүйцэтгэгч нарт бүрэн өгсөн, хамгаалах хэрэгсэл /амны хаалт, нэг удаагийн бээлий, улавч, нүүрний хаалт, гар ариутгагч гэх мэт/-ээр хангасан зэрэг нь алба хаагчдыг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлснийг харуулж байна.

Гэхдээ дээрх арга хэмжээнд анхаарах асуудал нэлээдгүй байсаар байна.

Судалгаанд оролцогчын 50 хувь нь ажлаа хийхийн тулд "Ковид 19"-ийн шинжилгээг 4-6 удаа өгсөн бөгөөд тэдний 75 хувь шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үедээ цар тахлын халдвар авсан байх магадлалтай гэж хариулсан. Үүнтэй холбогдон гарсан эмчилгээний зардлыг 100% өөрөө хариуцсан ба цар тахлын үед шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулснаараа гэр бүл, үр хүүхдээдээ эрсдэл учруулсан гэж 100% санал нэгтэйгээр хариулсан байна. Харин энэхүү эрсдэлт нөхцөл байдалтай холбоотойгоор учирсан хохирлоо арилгах талаар байгууллагаас арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй, өвчтэй, эмчилгээтэй байх үеийн цалинг хасалгүй олгох байдлаар дэмжлэг үзүүлсэн байна.

Мөн судалгаанд оролцогчид төлбөр төлөгчтэй уулзах, хаягаар явах, хөрөнгө битүүмжлэх, хөндлөнгийн гэрч оролцуулах зэрэг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бүхий л ажиллагааг гүйцэтгэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэж байсныг дурджээ.

Гэтэл энэ талаар зохион байгуулалтын арга хэмжээг удирдлагаас авч хэрэгжүүлээгүй нь хууль тогтоомжид энэ төрлийн харилцааг зохицуулаагүйтэй шууд холбоотой байна. Хэрэв энэ талаар хууль тогтоомжид тусгаж тогтоож өгсөн бол шийдвэр гүйцэтгэгч ажил үүргээ гүйцэтгэхтэй холбогдон гарсан зардал болон өөрт учирсан хор хохирлыг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлаас нөхөн гаргуулах баталгааг эдлэх боломжтой болох юм. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын гэрээнд шаардлагатай тохиолдолд нэмэлт зардлыг гаргуулах талаар нөхцөл дурдсан байдаг боловч цар тахлын үед буюу гамшигт байдалд ажиллахад шаардлагатай зардлыг гаргуулах талаар зохицуулалт байхгүй,

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд энэ талаар зохицуулалт байхгүй байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт, алба хаагчийн аюулгүй байдлыг ханган ажиллахад сөрөг нөлөөг үзүүлж байна.

Иймд цар тахлын үеийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үед алба хаагчийг эрсдэлээс хамгаалах, эрсдэлийг бууруулах, тэдэнд хохирол, хор уршиг учрахаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт, хамгааллын механизм шаардлагатай нь байгааг харуулж байна.

Дүгнэлт

Аюулгүй байдал судлалын асуудал нь өргөн хүрээтэй онолын агуулгыг өөртөө багтаадаг тул хүний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх биологийн гаралтай аюул, занал, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах нь аюулгүй байдал судлалын шинжлэх ухааны томоохон салбар болж байна.

Цар тахлын үед ажил үүргээ гүйцэтгэж, ард түмнийхээ аюулгүй байдлыг ханган ажиллах хүндхэн үүрэг төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдын нуруун дээр ирэв. Энэ хугацаанд үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахын хамт, өөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд цаашлаад ар гэр, үр хүүхэддээ хүртэл аюул, эрсдэл дагуулан очих тохиолдол бидний төрийн тусгай алба хаагч нарт тулгамдаж байсан юм. Энэ асуудал шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нарт мөн адил тулгарч байсан бөгөөд энэ асуудлыг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах шаардлагатай байгааг цар тахлын үед ажиллаж байсан шийдвэр гүйцэтгэгч нар дуу нэгтэйгээр дэмжсэн.

"Ковид 19"-ын тархалтын идэвхитэй үед шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулж байгаа шийдвэр гүйцэтгэгч нарыг гамшигаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хэрхэн ажиллах талаар тусгайлсан зохицуулалт бүхий эрх зүйн хэм хэмжээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд байхгүй, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын баталсан тушаалаар тухайн цаг үед авч хэрэгжүүлсэн төлөвлөгөө нь иргэний болон захиргаа зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэлийг тооцоолон төлөвлөөгүй байгаа нь цаашид гамшгийн тохиолдол үүсэх бүрт шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тулгамдсан асуудал болох эрсдэлтэй байна.

Судалгааны ажлыг бичих явцад цуглуулсан мэдээллээс харахад шүүхээс ирсэн гүйцэтгэх хуудсын тоо 10%-аар өссөн дүнтэй, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт 30%-аар буурсан үзүүлэлттэй, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх иргэдээс ирүүлсэн гомдлын тоо 17%-аар тус тус өссөн тоон үзүүлэлттэй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар "...төр нь иргэнийхээ зөрчигдсөн эрх, хөндөгдсөн эрх ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх үүрэгтэй" учраас ямарч тохиолдолд шүүхийн шийдвэрийн бодит биелэлтийг ханган ажиллах нь шийдвэр гүйцэтгэгч бүрийн үүрэг юм. Энэхүү үүргээ хэрэгжүүлэхэд төрөөс алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хамгаалах чиг үүрэгтэй. Гэвч өнөөдрийн байдлаар цар тахалтай холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааны харилцааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын баталсан төлөвлөгөөний хүрээнд гүйцэтгэх нь олон талын дутагдалтай байх бөгөөд цаашид энэхүү харилцааг энэ төлөвлөгөөгөөр зохицуулах боломжгүй юм.

Санал

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд цар тахал болон гамшигт байдлын үед шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрхэн зохион байгуулах арга, журмыг тодорхойлон тусгах;

2. Цар тахлын үед шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулахад гарсан зардалыг /гэрч, шинжээч оролцуулах, хөрөнгө тээвэрлэхтэй холбоотой зардал г.м/ шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэмэлт зардалд оруулан тооцдог байх;

3. Цар тахлын үед ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотойгоор шинжилгээ өгсөн, хамгаалалтын хувцас хэрэглэлээр хангагдсан, эмчилгээ хийлгэсэн зардалыг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардалаас санхүүжүүлэхээр хуульд тусгах;

4. Алба хаагч үүрэг гүйцэтгэх үедээ гоц халдварт өвчнөөр өвчилсөн тохиолдолд холбогдон гарах зардлыг байгууллага хариуцах зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

Ашигласан материалын жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 1992 он. №01

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2017 он. №24

3. Ч.Улаанхүү. Аюулгүй байдлын үндэс. УБ., 2016.

4. Ч.Улаанхүү. Аюулгүй байдлын онол арга зүйн асуудал. УБ., 2014

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын "Шинэ төрлийн коронавирус буюу "covid-19" өвчнөөс урьдчилан сэргийлэх болон халдварт өвчин гарсан тохиолдолд авах арга хэмжээний ажлын төлөвлөгөө" УБ., 2020 он.

6. Б.Батмөнх. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны удирдлага зохион байгуулалт магистрын зэрэг горилсон судалгааны ажил. УБ., 2022 он

7. Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн систем https://1313.mn/mn/

8. COVID Live - Coronavirus Statistics – Worldometer. https://www.worldometers.info › coronavirus

Нийгмийн ажил

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН НИЙГМИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

SOCIAL SECURITY OF PRISON SOCIAL WORKER



П.Баярбаатар
Дотоод хэргийн их сургуулийн докторант, хошууч
Мэйл хаяг: Bayarbaatar405@gmail.com

Хураангуй: Энэхүү өгүүлэлд нийгмийн ажилтны ажил үүрэг, онцлог зэрэгт дүн шинжилгээ хийж, сэтгэл зүйн бэлтгэлийг тодорхойлохыг зорьсон болно.

Бид судалгааны боловсруулалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа нээлттэй, хаалттай хорих ангийн нийгмийн ажилтнаас судалгаа авч ажлаас халшрах хам шинжид нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээг хийж судалгаанд онолын болон практикийн асуудлыг авч үзэн өгөгдлийг SPSS 26 программ хангамжаар шинжилсэн.

Abstract: *This article aims to analyze the role and characteristics of a social worker and determine psychological preparation.*

We developed the research by taking a survey of social workers of open and closed prisons under the General Executive Agency of Court Decision, analyzing the factors affecting burnout syndrome, considering theoretical and practical issues in the research, and analyzing the data with SPSS 26 software.

Түлхүүр үг: Хоригдол, суллагдахад бэлтгэх, хорих байгууллагын нийгмийн ажил, хоригдлыг нийгэмшүүлэх, засрал хүмүүжил, сургалт.

Key words: *prisoner, preparing for release from prison, social work in prisons, socialization of prisoner, upbringing, training*

Удиртгал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдлагын шийдвэр, Их дээд сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд 2003 оноос эхлэн хоригдлыг нийгэмд дасан зохицуулах, тэдгээрт тулгарсан бэрхшээлийг даван туулахад туслах чиг үүрэг бүхий албан тушаалтны орон тоо

батлагдсанаар өнөөгийн "Хорих байгууллагын нийгмийн ажилтан[12]" гэсэн нэр томьёо гарч мэргэжлийн үйл ажиллагаа нэвтэрч эхэлсэн.

Хоригдлыг хуульд захирагдах, өөрийн үйлдлийн хариуцлагыг хүлээж сургах, иргэний эрхийн бодит зүйл болгох нөхцөлийг бий болгож байгаагаараа хоригдолд чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ нь нийгмийн зайлшгүй шаардлагаар бий болсон онцлогтой[13] гэж үздэг.

Гэсэн хэдий боловч хоригдлыг нийгэмшүүлэх ажлын зарим нэг хэлбэр болох хүмүүжүүлэх, сургах, сурган гэгээрүүлэх, тусламж үзүүлэх, дэмжих, боловсрол олгох үйл ажиллагаа нь 100 орчим жилийн түүхтэй гэж судлаачид үздэг. Учир нь 1924 оны 11 сард хуралдсан Улсын анхдугаар Их хурлын тогтоолын Шүүх яамны тухай хэсэгт, МАН-ын 3-р их хурлын тогтоолд тус тус "Гянданаа бүхий хэрэгтэн ардыг үйлдвэрт сургах, сургаж гэгээрүүлэх..... аливаа хэрэгтэн ардын дотроос хүн төлөв, засрах боломжтойг нь хорихгүйгээр үйлдвэр хийлгэвэл зохих[14]" гэж онцлон тэмдэглэсэн байдаг.

Энэхүү түүхэн уламжлал, шинэчлэлийг түүчээлэн авч яваа үе үеийн гэгээрүүлэх, сургах, тусламж дэмжлэг үзүүлэх болон нэг үгээр хэлбэл нийгэмшүүлэх үйлчилгээг үзүүлж байсан алба хаагчдын залгамж халаа бол өнөөдрийн хорих байгууллагын нийгмийн ажилтан гэж хэлж болно.

Тэгвэл хорих байгууллын нийгмийн ажилтан хоригдолтой ажиллахдаа тэдний сэтгэл зүйн хувийн онцлогийг танин мэдэж, хүн нэг бүрт тохирсон сургалт, хүмүүжлийн ажлыг зохиосноор үр дүнд хүрдэг байна. Хоригдлын авир араншинг хэрхэн танин мэдэхээс нийгэмшүүлэхэд чиглэгдсэн хөдөлмөр, дэглэм, сургалт, боловсрол олгох ажлын үр нөлөө шалтгаална.

Энэхүү мэргэжлийн ажил нь өргөн талбартай бөгөөд нэг талаас нийгэмд аюултай гэмт хэрэгтэн, нөгөө талаас нийгмийн төгөлдөр бус байдал буюу ажилгүйдэл, архидалт, тааламжгүй бичил орчин, ямар нэгэн буруу нөлөө үзүүлэгчдийн нөлөөнд автах, гадна, дотны нөхцөл байдал муу, бие сэтгэл зүйн хөгжил сул, сурган хүмүүжүүлэх ажиллагаа дутагдсан, амьдралын бэрхшээлээс гарахад нь туслаагүй, тэр ч бүү хэл байгалийн сөрөг үзэгдлийн хохирогч болсон хүний бэрхшээлийг даван туулахад нь чиглэгдсэн цогц үйл ажиллагааны үр дүн юм гэж судлаачийн зүгээс үздэг.

Өөрөөр хэлбэл нийгмийн асуудалтай хоригдолд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүмүүжлийн нөлөөллөөр дамжуулан

---

[12] Алтангэрэл Б., Хүрэлбат М. Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажилд хийсэн шинжилгээ. Уб., 2020. 39 дэх тал.

[13] Амаржаргал.Т, Оюунбилэг Т, Ариунтуяа Н. нар. Хорих байгууллага дахь нийгмийн ажил. Уб, 2013. 11 дэх тал.

[14] А.Лхагва, 2011, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал, Мөнхийн үсэг

хязгаарлагдаагүй эрхийг хангах, боломжийг нь өргөжүүлэх, харилцаан дахь бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх, эерэг өөрчлөлтийг нь дэмжих зорилтыг хангахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг төрийн тусгай чиг үүрэгтэй мэргэжилтэн гэж хэлж болно.

Өнөөдрийн байдлаар хорих байгууллагад ажиллаж буй 66 нийгмийн ажилтан 50 гаруй салбар нэгжид 3000 орчим хоригдогч, 4000 гаран хоригдлыг хорих ял эдлэх хугацаанд нь ганцаарчилсан болон бүлгийн уулзалт зөвлөгөө өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх, сэтгэл зүйн хувьд тогтворжуулах, харилцааны бэрхшээлийг шийдвэрлэх, суллахад бэлтгэх чиглэлээр сургалт, яриа таниулга зэрэг нөлөөллийн бүхий л ажлыг зохион байгуулж холбон зуучлан ажиллаж байна.

Хорих байгууллагын нийгмийн ажилтны өдөр тутмын ажлаас дурдвал өнгөрсөн онд 629 хоригдлыг бичиг баримтжуулсан, 315 хоригдлыг сайн дурын даатгалд хамруулан 1,299,500,000 төгрөгийг хоригдлын хөдөлмөрийн хөлс, ар гэр, төр, төрийн бус байгууллагаас гаргуулан нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн бол бусдад төлөх хохирол төлбөртэй 1049 хоригдлыг ажлын байраар хангах, холбон зуучлах, ухуулан сэнхрүүлэх зэрэг олон талт ажлыг зохион байгуулсны үр дүнд нэг тэрбум гаран төгрөгийг хохирогчид шилжүүлэн хохирлыг хэсэгчлэн болон бүрэн барагдуулсан байна[15].

Нийгмийн ажилтан хоригдолтой уулзалт хийх, судалгаа авах явцдаа дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлын дийлэнх нь мэргэжилгүй, суллагдан гараад ажлын байр олдоггүй, хүлээн авах орчин, нөхцөл муу, нийгэмд дасах явц удаан явагддаг, нийгмийн халамж шаардлагатай болдог зэргээс шалтгаалан гэмт хэрэг, зөрчилд холбогдож байгааг дурдсан байдаг.

Ийнхүү тулгарч буй зарим асуудлыг шийдвэрлэх зорилгоор нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөн жилд дунджаар 8 мэргэжлээр 300 гаран хоригдолд мэргэжлийн боловсрол олгосон бол, 12 мэргэжлээр 400 гаран хоригдолд мэргэжлийн чадамжтай болгон бэлтгэснээс гадна дээрх хэмжээний хоригдлыг суллагдан гарахад ажлын байранд зуучлан хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэх боломжтой болгосон байна.

Хором зуурт бүх зүйлийг засах боломжгүй. Гэхдээ юуны өмнө аливаа нөхцөл байдалд хандаж буй хандлагыг нь өөрчилж эхлэх хэрэгтэй. Хүний сэтгэл оюуныг ашид сайн сайханд урвуулж чадна[16] гэдэгчлэн хорих байгууллагын нийгмийн ажилтан бүр ажиллаж хөдөлмөрлөж ирсний үр дүнд өөрийн үнэ цэнэ амьдралын утга учрыг ойлгосон нийгэмд сайн сайхан амьдарч буй иргэдийг бэлтгэн гаргаж байгааг дурдах нь зүйтэй байна.

Нөгөө талаас гэр бүл, найз нөхдийнхөө өмнө алдсан, төөрөлдсөн олон олон гэмт хэрэгтэн бие хүнд нөлөөлж зөв замд нь оруулах, ар гэрт нь

---

[15] ШШГЕГ-ын Сургалт, нийгэм, сэтгэл зүйн хэлтсийн 2021 оны тайлан.

[16] Их хөлгөн, 2020, Амьдралын 16 эрдэм

эргэж нэгтгэх, дахин нийгэмшүүлэх, шударга ёсыг ойлгуулах ажил амар биш, энэ амаргүй ажлыг хийж байгаа хүн бол хорихын нийгмийн ажилтан юм.

Нийгмийн ажилтны нийгмийн хамгаалал, сэтгэл зүйн тулгамдаж буй асуудал

Монгол төрийн төлөө, Монголын нийгмийн ажлын хөгжлийн төлөө сэтгэлтэй, зүтгэлтэй, идэвх чармайлттай чадварлаг нийгмийн ажилтан бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гэлтгүй эх орон ард түмэнд баялгийг бүтээж хөгжлийг авчирдаг гол хүч юм.

Гэтэл нийгмийн ажилтан ажил, мэргэжлээс шалтгаалан олж авсан сөрөг таагүй мэдээлэл нь санаа зовох, сэтгэлээр унах, өөрийгөө дорд үзэх, дарамтад орох зэрэг сэтгэл зүйн бэлтгэлгүй байдал нь хувийн болон албан харилцааны асуудлыг амжилттай шийдвэрлэхэд муугаар нөлөөлдөг байна.

Ийнхүү нийгмийн ажилтан бэлтгэлгүй энэ байдалдаа дасан зохицож би угаасаа ажил дээрээ ямар нэгэн амжилт гаргаж чадахгүй, энэ хэвээрээ хүнд анзаарагдахгүйгээр өдөр хоногийг өнгөрүүлье, болохгүй бол ажлаас гарна гэсэн хандлагатай ажиллаж, амьдарч байгаа нийгмийн ажилтан нэлээдгүй тааралдах болсон нь анги, байгууллагад ажиллах нийгмийн ажилтанд тулгарсан нөхцөл байдлыг ойлгож, үнэлэх, дэмжлэг үзүүлэх хэрэгцээ байна.

Нөгөөтээгүүр өөрчлөн шинэчлэгдэж байгаа хууль, нийгмийн шаардлагын хүрээнд нийгмийн ажилтны ажилдаа хандах хандлагыг сайжруулах, мэдлэг ур чадвар, бусад нөөц бололцоог нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх эерэг зан үйлийг төлөвшүүлэх, ажлаас халшрах хам шинжээс сэргийлэхэд сэтгэл зүйн дархлаажуулалтын менежментийг хэрэгжүүлэх, түүнд нөлөөлж буй нийгэм сэтгэл зүйн хүчин зүйлүүдийг нарийвчлан судлах хэрэгцээ тухайн байгууллагын тулгамдсан зорилт болон тавигдаж байна.

Судлаачийн зүгээс хорих байгууллагын нийгмийн ажилтны дунд ажлаас халшрах хам шинжийг судалгааг хийж үзэхэд судалгаанд нээлттэй, хаалттай 25 хорих анги, баривчлах төв, байр, орон нутаг дахь шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн 49 нийгмийн ажилтан оролцсон нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд ажиллаж буй нийгмийн ажилтны 74.2 хувийг эзэлсэн болно.

Ажлаас халшрах хам шинж гэдэг нь ямар нэгэн юмыг бүтээн бий болгох биеийн болон оюуны үйл ажиллагаанаас бэрхшээх, зүрхшээх сэтгэцийн эмгэг өвчний харилцан уялдаатай олон шинжийн цогцолбор гэж монгол хэлэнд утгачлан тайлбарладаг байна.

Ажлаас халшрах хам шинжийн нөлөөгөөр ажилтан ажил, мэргэжлийн хувьд тодорхой хэмжээгээр бүтээмж бууралтад ороход байгууллагын зүгээс ашиг орлого, гүйцэтгэл буурах, бүтээмж багасах сөрөг нөлөөтэй байдаг бол ажилтны зүгээс бие сэтгэцийн эрүүл мэндийн

хувьд хүндрэл бэрхшээлтэй удаан хугацааны явцад тулгарах нөхцөл бүрддэг тул байгууллага, ажилтан аль аль нь эрсдэлтэй нөхцөл байдалд ордог гэж үздэг.

Зураг 1. Судалгаанд хамрагдагсдын нас: *Зураг 2. Судалгаанд хамрагдагсдын хүйс:*





Судалгаанд 22-52 насны 49 нийгмийн ажилтан хамрагдсан ба 47 наснаас дээш настай алба хаагчид хамгийн бага 2 буюу 4,1 хувийг, 26-30 насны алба хаагчид хамгийн их 17 буюу 34.7 хувийг эзэлж байна.

Судалгаанд оролцсон нийгмийн ажилтнуудын 81.6 хувь буюу 40 эмэгтэй алба хаагч 18.4 хувь буюу 9 эрэгтэй алба хаагч хамрагдсан байна.

Зураг 3. Хоригдлын зүгээс нийгмийн ажилтанд халдах, занал хийх тохиолдол гаргаж байсан талаарх асуулга:



Судалгаанд хамрагдсан нийгмийн ажилтнаас албан үүргээ гүйцэтгэж байх хугацаанд хоригдлын зүгээс дарамт шахалт ирж байсан эсэх асуултад 1 алба хаагч буюу 2 хувь нь хүч хэрэглэн халдаж байсан, 27 алба хаагч буюу 55.1 хувь нь хэл амаар доромжилж байсан, 6 алба хаагч буюу 12.2 хувь нь хувийн харилцаа тогтоохыг оролдож байсан, 5 алба хаагч буюу 10.2 хувь нь бусад хэлбэрээр дарамт шахалт үзүүлж байсан, 10 алба хаагч буюу 20.4 хувь нь хоригдлын зүгээс ямар нэгэн занал хийх буюу сөрөг үр дүн үзүүлж байгаагүй талаар хариулсан байна.

Энэхүү тоон үзүүлэлтээс харахад судалгаанд хамрагдсан нийгмийн ажилтны 79.6 хувь нь албан үүргээ гүйцэтгэхтэйн холбогдуулан биеийн

болон сэтгэл зүйн хувьд дарамт шахалтад өртсөн буюу тэр дундаа хоригдлын зүгээс доромжлох буюу нэр төр алдар хүндийн албан үүрэгтэй холбогдуулан үг, үйлдлээрээ гутаасан, гүтгэсэн үйлдэл гаргаж байсан байна.

Зураг 4. Нийгэмшүүлэх ажлын хамтын ажиллагаанд тулгарч буй бэрхшээл:



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 218 дугаар зүйлийн 218.3-т "Хорих анги дахь нийгэмшүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтаас санхүүжүүлж болон", 219 дүгээр зүйлийн 219.2-т "Нийгэмшүүлэх ажилд хорих ангийн алба хаагчаас гадна бусад байгууллага, иргэнийг оролцуулж болон" гэсэн заалтыг хэрэгжүүлэх, хоригдлыг нийгэмшүүлэх ажилд хамтран ажиллах ажлын хүрээнд төрийн бус байгууллагатай хамтран ажиллахад хүндрэл бэрхшээл тулгардаг талаар 19 нийгмийн ажилтан буюу 38.8 хувь, хорих ангийн дотоодын нэгж, тасагтай хамтран ажиллахад хүндрэл учирдаг талаар 17 нийгмийн ажилтан буюу 34.7 хувь, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид хоорондоо баг болж ажиллаж чаддаггүй гэж 9 нийгмийн ажилтан буюу 18.4 хувь, мэргэжлийн удирдлагаар хангах сургалт, нийгэм, сэтгэл зүйн хэлтэстэй хамтран ажиллахад бэрхшээлтэй талаар 4 нийгмийн ажилтан буюу 8.2 хувь нь хариулсан байна.

Ажлаас халшрах хам шинжийг илрүүлэх сорилын найдварт чанарын шалгахад (r.0,824) буюу найдвартай үр дүн гарсан учир судалгаанд энэхүү арга зүйг ашигласан болно. Судалгаанд оролцсон нийгмийн ажилтны ажлаас халшрах хам шинжийн түвшинг тодорхойлж үзэхэд дараах үр дүн гарч байна.

Зураг 5. Нийгмийн ажилтны ажлаас халшрах хам шинжийн ерөнхий индекс:



Судалгаанд хамрагдсан 49 нийгмийн ажилтны 1 буюу 2 хувьд нь ажлаас халшрах хам шинж илрээгүй сайн үзүүлэлттэй гарсан, 3 буюу 6.1 хувьд ажлаас халшрах хам шинжид өртөж эхэлсэн, 89.7 хувь буюу 44 алба хаагчид ажлаас халшрах хам шинж дундаас дээш түвшинд илэрсэн дүн гарсан. Үүнээс 6 алба хаагч буюу 12.2 хувь нь хам шинж өндөр буюу ажил, мэргэжлээс шалтгаалсан өөрчлөлт, эмгэг нэлээдгүй бий болсон байна.

Энэ нь ажлаас халшрах хам шинжийн түвшин нэмэгдэхэд ажилтан ажиллах эрч хүчгүй болох, хүмүүстэй харьцах явцад зөрчилдөх нь ихсэх, амьдралын утга учир, үнэт чанарын талаарх мэдрэмж сулрах, өөртөө итгэх итгэл алдрах, бусад хүмүүсийн санаа бодол, мэдрэмжид хайхрамжгүй хандах буюу хүнлэг чанар буурах, бусадтай харилцаанд орох, сэтгэл хуваалцлаас төвөгшөөж зожгирох зэрэг шинж тэмдгээр хам шинж илэрч байдаг байна.

Тэгвэл ажлаас халшрах хам шинж нь нийгмийн ажилтанд ядрах, нойргүйдэх, аливаа зүйлийг эергээр хүлээн авахаа болих, хүмүүст шүүмжлэлтэй, хүнлэг бусаар хандах, өөрийн үүргийг гүйцэтгэх хүсэлгүй болох, ажилдаа хойрго хандах, урт завсарлага авах, хоцрох, эсвэл ажлаасаа эрт гарах хувийн хэрэгцээндээ төвлөрөөд амьдралын зорилгоо алдах, атаархалд автах, сэтгэл гутрал, депресс өртөх, хардамтгай болох, эргэн тойронтойгоо зөрчилдөх, үйл ажиллагааны үр өгөөж буурах, даалгаврыг зөвхөн зааврын дагуу гүйцэтгэх, никотин, кофе, согтууруулах ундаанаас хамааралтай болох донтох магадлал өндөр болдог гэж эрдэмтэд үздэг.

Согтууруулах ундаа, никотин, кофе зэргээс хамааралтай болох эмгэг гэдэг нь дээрх зүйлийг хэтрүүлэн хэрэглэснээс үүдэлтэй нийгэм, сэтгэц болон бие махбод физиологийн дасан зохицох байдалд эмгэг хямрал үүсгэгч хэлбэрээр явагддаг бөгөөд ажилтан ажлаасаа гарах нэгэн шалтгаан болдог байна.

Судалгаанд хамрагдсан нийгмийн ажилтны ажлаас халшрах хам шинжийг бүрдүүлдэг шинжийн нэг болох сэтгэл зүйн шавхагдалд 28

нийгмийн ажилтан буюу 57.1 хувь нь өндөр түвшинд, 18 нийгмийн ажилтан буюу 36.7 хувь нь дунд түвшинд илэрсэн бөгөөд нийгмийн ажилтны 93.8 хувь нь сэтгэл зүйн шавхагдал буюу тамирдалтад өртсөн үзүүлэлттэй байна. Энэ нь мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой үүсэж байгаа сэтгэл хөдлөлийн дарамттай байдал, биеийн болон сэтгэлийн энергийн бууралтыг харуулсан байдаг.

Сэтгэл зүйн шавхагдлыг сэтгэл зүйн тэнхээ алдрах эмгэг шинж гэх ойлголтоор тайлбарлаж болох юм. Мөн өндөр цалингаас илүү хийж буй ажлаас авах сэтгэл ханамж чухал гэсэн асуултад тийм гэсэн хариултыг 19 нийгмийн ажилтан буюу 38.8 хувь, заримдаа гэж 27 нийгмийн ажилтан буюу 55.1 хувь, үгүй гэж 3 нийгмийн ажилтан буюу 6.1 хариулснаас харахад ажлаас авах сэтгэл ханамж нь сэтгэл зүйн шавхагдал буюу тамирдалтаас сэргийлэхэд эерэг нөлөө үзүүлдэг гэж хэлж болохоор байна.

Харилцаа холбооны хөндийрөлд 18 нийгмийн ажилтан буюу 36.7 хувь нь өндөр, 15 нийгмийн ажилтан буюу 30.6 хувь нь дунд түвшинд илэрсэн бөгөөд нийгмийн ажилтны 67.3 хувь нь хүмүүстэй харилцаа, холбоо тогтоохоос зайлсхийх, эсвэл цөөрүүлэх, харилцаа үүссэн нөхцөлд уцаарлах, бухимдах, зөрчилдөх, хамт олондоо эргэлзэх, сөрөг хандлагатай болсон үр дүн үзүүлсэн байна. Энэ нь нэг талаас хэцүү үйлчлүүлэгч буюу сэтгэл зүйн байдал тогтворгүй буюу амархан уурлаж бухимдах гутрах хэв шинжтэй, өвчтэй, сэтгэцийн эмгэгтэй, харилцааны соёлгүй буюу зохимжгүй яриатай, өөрийгөө зөвөөр илэрхийлэх чадвар муутай, хүндхэн зан төлөвтэй дарамт шахалт үзүүлэх гэж оролдох, өөрийн эрхшээлдээ байлгах сонирхолтой хоригдол бие хүнтэй өдөр бүр ажилладгаас харилцаа холбооны хөндийрөлд орох магадлал өндөртэй болдог байна.

Ажлаас халшрах хам шинж нь зөвхөн нийгмийн ажилтанд байна уу гэвэл өрөөсгөл ойлголт юм. Учир нь энэ нь хүнтэй ажилладаг мэргэжилтэнд илрэх хандлагатай байдаг ба жишээ нь эмч, багш, харуул хамгаалалтын ажилтан гэх мэт хүмүүст нийтлэг тохиолддог гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

Шалтгаан нөхцөлийг нь судлан эрэмбэлэн үзвэл дараах нийтлэг хүчин зүйл нөлөөлсөн байна.

- ажилдаа хэт их чармайх буюу ажлаа бодит бусаар төсөөлөх

- хэт их оролцоо буюу үндсэн ажилтай холбоогүй ажилд цаг зав хүч нөөцөө их зарцуулах

- ажил үүргийн тодорхойгүй байдал, ажлын байрны тодорхойлолтоо мэдэхгүй байх

- ажлын ачаалал хэт их эсвэл хэт бага байх

- байгууллагын тодорхойгүй зохион байгуулалт буюу ажил амралтын цагийг зохицуулахгүй байх

- ажлын хэрэгцээт зүйлээр дутах, хангагдахгүй байх

- удирдлагын арга барил нийгмийн ажилтан хоорондын үл ойлголцол

- хамт ажиллаж буй алба хаагчдын хоорондын харилцааны зөрчил

- албан тушаалын карьер өсөх боломж тодорхойгүй байх

- хэцүү үйлчлүүлэгчид буюу сэтгэцийн өөрчлөлттэй хоригдол, харилцааны хувьд доголдолтой хүнтэй тогтмол ажиллах

- урамшуулал, цалин хөлс нэмэгдэхгүй байх зэрэг нь голлон нөлөөлдөг байна.

Дүгнэлт, санал

Нийгмийн ажилтны 89.7 хувь буюу 44 алба хаагчид ажлаас халшрах хам шинж дундаас дээш түвшинд илэрсэн дүн гарсан нь ажил, мэргэжлээс шалтгаалсан өөрчлөлт, эмгэг нэлээдгүй бий болсон байгааг харуулж байна.

Ажлаас халшрах хам шинжийг бүрдүүлж байгаа үзүүлэлтийг тус бүрээр авч үзэхэд албан хаагчдын 93.8 хувь нь сэтгэл зүйн шавхагдал буюу тамирдалтад өртсөн, сульдалт, тамирдалтын өндөр түвшинд, 67.3 хувь нь харилцаа холбоо хөндийрлийн өндөр түвшинд, 22.5 хувь нь ажлын амжилтын бууралтын дунд ба түүнээс дээш түвшинд байна. Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын хөдөлмөр, үйлчилгээний өвөрмөц онцлог байдал нь тэдний сэтгэл санаа болон харилцаанд нөлөөлж ажлаас халшрах хам шинжийг нэмэгдүүлэх бодит шалгаан болж байна гэж үзэж байна.

Нийгмийн ажилтны ажлаас халшрах хам шинжийг тэдний боловсрол, мэргэжил, албан тушаал, хүйс, ажилласан жилтэй холбон судалж үзэхэд ажилласан жилтэй шууд хүчтэй хамааралтай ба ажилласан жил нэмэгдэхийн хэрээр ажлаас халшрах хам шинж өсөх хандлагатай болохыг анхааран үзэж, түүнийг бууруулах менежментийг хүйсийн онцлог болон ажилласан жилийн мөчлөгт зохицуулан явуулах шаардлагатай байна.

Иймд хорих байгууллагад ажиллах мэргэжлийн нийгмийн ажилтны сэтгэл зүйн бэлтгэлийг сайжруулах, ажлаас халшрах хам шинжийг бууруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, тухайн байгууллагын үйл ажиллагааны менежментийг сайжруулах нь чухал гэж үзэж байна.

Ашигласан материалын жагсаалт

Нэг.Хууль,тогтоомж:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /шинэчилсэн найруулга/. 2017

2. Нийгмийн ажилтны аргачилсан заавар. 2017

3. Сэтгэл зүйн ажлын заавар. 2017

Хоёр.Ном, сурах бичиг, гарын авлага:

4. Т Амаржаргал, Т.Цэндсүрэн, Оюунбадам Р. Хорих байгууллага дахь нийгмийн ажил.

УБ. 2013

5. М.Ариунцацрал, Л.Сайханцэцэг. Нийгмийн ажлын онол, арга зүйн үндэс. УБ. 2012

6. Б.Алтангэрэл. Хорих ял эдлүүлэх ажиллагаа.УБ.2018

7. Б.Алтангэрэл. Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ.УБ.2019

8. Б.Алтангэрэл. Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажилд хийсэн шинжилгээ. УБ., 2020

9. Б.Баярмаа, У. Мэргэнбаяр Нийгмийн ажил. УБ., 2006

10. М. Батбаатар. А. Батхишиг. Нийгмийн ажил. УБ. 2017

11. Б.Туяа. Бие хүний сэтгэл зүй, сэтгэц заслын өрнөдийн онол, гол төлөөлөгчид.

УБ.2003

12. Г. Түмэннаст. Нийгмийн ажил. УБ. 2019

13. Л.Уранцэцэг, М.Дэлгэржав. Нийгмийн сэтгэл судлал. УБ.,2012

14. А.Гидденс. Социологи.УБ.,2006

15. Д.Солонго. Хувь хүнтэй ажиллах нийгмийн ажил. УБ., 2010

16. Ц. Очгэрэл, Д. Дамдинцэрэн, Г.Галбадрах. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үүсэл, хөгжлийн түүхэн товчоон. УБ., 2021

17. М. Хишиг-Ундрах. Хуулийн сэтгэл судлал. УБ., 2021

Гурав.Судалгааны тайлан, бусад материал:

18. С. Энхтуяа, Д. Олончимэг, Н. Оюун-Эрдэнэ "Монгол Улс дахь Нийгмийн ажлын хөгжил" судалгааны тайлан. УБ., 2008

19. ШШГСудлал сэтгүүл

20. Нийгмийн хамгааллын сүлжээ техник туслалцааны ТА 2978-Мон төсөл. Кэйф Огрборн, Петер Хамфрис. Монголын нийгмийн ажлын хөгжил тайлан. УБ., 2002.

Дөрөв.Цахим хаяг:

21. www.cd.gov.mn
22. www.mojha.gov.mn
23. www.legalinfo.mn

Гэмт явдал судлал

СОВРЕМЕННЫЕ ИННОВАЦИОННЫЕ ПОДХОДЫ ПРИ ПОДГОТОВКЕ БУДУЩИХ СПЕЦИАЛИСТОВ ПО ПРОТИВОДЕЙСТВИЮ ПРЕСТУПНОСТИ

MODERN INNOVATIVE APPROACHES TO THE TRAINING OF FUTURE CRIME COUNTER SPECIALISTS



ХАРМАЕВ ЮРИЙ ВЛАДИМИРОВИЧ

Заведующий кафедрой уголовного процесса и криминалистики ЮФ Бурятского государственного университета, к.ю.н., доцент,

Заслуженный юрист РБ (670000, г.Улан-Удэ, улица Сухэ Батора, 6) т.ф. (3012) 297160, e-mail: kharmaev@mail.ru

Аннотация: В статье автором затрагиваются вопросы по использованию инновационных подходов по подготовке будущих специалистов в сфере исполнения наказания. Основное внимание уделено особенностям преподавания дисциплины «Уголовно-исполнительное право» в современных условиях. Внесение многочисленных изменений в отечественное антикриминальное законодательство, а также в подзаконные акты, регламентирующие практику исполнения уголовных наказаний, обусловило повышенное внимание к такой отрасли российского права как, уголовно-исполнительное право. Роль и значение предмета «Уголовно-исполнительное право» и других дисциплин антикриминального цикла в учебном процессе по подготовке бакалавров должна быть пересмотрена в соответствии с изменившимися реалиями, что позволит студентам более эффективно усваивать знания в области пенитенциарных правоотношений.

Annotation: *In the article, the author touches upon the issues of using innovative approaches to the training of future specialists in the field of punishment execution. The main attention is paid to the peculiarities of teaching the discipline "Criminal Executive Law" in modern conditions. The introduction of numerous changes in the domestic anti-criminal legislation, as well as in by-laws regulating the practice of executing criminal penalties, has led to increased attention to such a branch of Russian law as penitentiary law. The role and significance of the subject "Penal Law" and other disciplines of the anti-criminal cycle in the educational process for the preparation of bachelors should be reviewed in accordance with the changed realities, which*

will allow students to more effectively acquire knowledge in the field of penitentiary legal relations.

Ключевые слова: уголовно-исполнительное право; традиционные формы преподавания; самостоятельная работа; инновационные подходы преподавания дисциплин; учебный процесс; практика; апробация; юридические кадры.

Keywords: *penitentiary law; traditional forms of teaching; independent work; innovative approaches to teaching disciplines; studying proccess; practice; approbation; legal staff.*

В контексте противодействия преступности в современных условиях безусловно возрастает роль и значение высших учебных заведений, готовящих будущих юристов. Стремительный рост новейших технологий, расширение социального пространства, научно-технический прогресс, развитие и модернизация всех сфер человеческих отношений прямо повлияли и на качественные изменения преступности.

Сегодня правоохранительные органы, как показывает практика, сталкиваются в своей повседневной деятельности с новыми преступными проявлениями, которые могут принести обществу гораздо больший материальный и моральный ущерб. И, к сожалению, национальное законодательство не всегда успевает своевременно и эффективно реагировать на это правовыми средствами, адекватно реагировать на вызовы со стороны представителей преступного мира.

В данных условиях очень важная роль выпадает на те институты государства, которые должны готовить кадры для правоохранительных органов, именно специалистов, способных эффективно противостоять в таких условиях криминалу. В Российской Федерации традиционно сложилась система подготовки кадров, использующая ведомственные высшие учебные заведения, например МВД, ФСБ, ФСИН и др. Однако, несмотря на существование достаточного количества специальных учебных подразделений, мы наблюдаем, что не всегда правоохранительные органы в регионах формируются за счет таких выпускников. Поэтому и гражданские классические юридические учебные заведения, как правило, являются активным поставщиком будущих специалистов в сфере противодействия преступности.

Подготовка кадров для правоохранительных органов является одной из основных в деятельности вышеперечисленных подразделений. К сожалению, в современных условиях текучесть кадров, невысокий уровень сотрудников имеющих высшее юридическое образование в различных подразделениях ОВД – это далеко не полный перечень тех факторов, которые негативно влияют на оперативно-служебную деятельность, и, в конечном счете, на результаты борьбы с преступностью. Поэтому обучение практических сотрудников является уже одной из форм взаимодействия между профессорско-преподавательским составом и представителей территориальных

подразделений ОВД. О значимости и актуальности такого взаимодействия говорилось неоднократно, и следует подчеркнуть, что такое взаимоотношение взаимовыгодное.

Для достижения поставленных целей перед преподавательским составом стоит задача совершенствования современной методики преподавания и ее соответствия сегодняшнему дню. Хотелось бы сформулировать и некоторые предложения по повышению качества преподавания дисциплин, в частности, антикриминального цикла, на примере преподавания дисциплины «Уголовно-исполнительное право» (далее УИП).

Изучение УИП призвано обеспечить усвоение слушателями нового законодательства в области исполнения уголовных наказаний, а также иных мер уголовно-правового характера. Слушатели обязаны в соответствии с профессиональными компетенциями[17] овладеть теоретическими знаниями и определенными правоприменительными навыками в области правового регулирования исполнения уголовных наказаний, необходимыми для профессионального осуществления деятельности в сфере уголовно-исполнительного законодательства и проведения профилактических мероприятий в борьбе с преступностью в пенитенциарной системе.

Особенность преподавания дисциплины УИП отличается тем, что большой объем изучаемого материала приходится на самостоятельную подготовку. Нам видится несколько аспектов, на которые необходимо обратить внимание.

1). Учитывая, что профессия юриста в будущем предполагает публичность, открытость, общение с большим количеством людей, необходимо у наших студентов развивать навыки комуникативности. Озвучивание докладов, реферативных выступлений перед своими коллегами-студентами, позволит стеснительным студентам побороть свой страх.

2). Самостоятельная работа с первоисточниками. Нормативно-правовые акты, регламентирующие деятельность пенитенциарных органов - разные по объему и по содержанию. Как правило, время для выступления примерно одинаково для всех, поэтому у них (студентов) вырабатываются навыки анализа и изучения правового документа,

---

[17] Приказ Министерства образования и науки РФ от 04.05.2010, № 464 «Об утверждении и ведении в действие Федерального государственного образовательного стандарта высшего профессионального образования по направлению подготовки 030900 Юриспруденция (квалификация (степень) «бакалавр»).

подготовка материала для будущего доклада с учетом регламента по времени.

3). Выступление должно содержать небольшой, рассчитанный на 5-7 минут материал, раскрывающий суть вопроса. После выступления докладчиков предусмотрено время для обсуждения заданной темы, и возможность выступающего ответить на возникшие у аудитории вопросы. Преподаватель должен контролировать ход ведения занятия, при необходимости задавая наводящие вопросы, как докладчикам, так и аудитории, при этом вовлекая в полемику как можно больше слушателей. Задача преподавателя сводится к тому, чтобы на семинарском занятии помимо выступления докладчиков, в обсуждении изучаемых вопросов выступило как можно больше слушателей, которые высказали бы свое суждение по теме.

4). Для более полного усвоения теоретического материала по УИП, предлагается использование учебных фильмов по дисциплине, отдельные сюжеты из известных телепередач, например, «Криминальная Россия», «Внимание розыск», «Легенды советского сыска», «Независимое расследование», «Следствие вели…», «Чрезвычайное происшествие» и др.

Как показывает практика, просмотр учебных фильмов, построенных на реальных событиях, позволяет студентам быстрее и эффективнее понять пройденный теоретический материал по дисциплине УИП. Перед просмотром сюжетов необходимо студентам дать задание, определить перечень вопросов, на которые студенты должны подготовить ответы. Опрос слушателей, по нашему мнению, следует проводить либо устно, либо письменно.

5). Отдельные темы по курсу УИП эффективнее проводить с приглашением сотрудников уголовно-исполнительной системы, в частности, по темам: «Правовое положение сотрудников персонала уголовно-исполнительной системы», «Порядок исполнения уголовных наказаний, не связанных с лишением свободы», «Особенности отбывания уголовных наказаний отдельной категорий граждан» и др. Доклад приглашенных гостей должен содержать в себе не только теоретические выкладки по теме, действующие нормативно-правовые источники, но и проблемные аспекты, присущие для их ведомства. После выступления приглашенных гостей по вышеуказанным темам, необходимо оставить время для интересующих студентов вопросов.

Хотелось бы также сформулировать и некоторые предложения по повышению качества преподавания дисциплин антикриминального цикла.

1. В связи с тем, что диплом бакалавра дает право трудиться в правоохранительных органах (хотя и не во всех), следовало бы увеличить количество и объем часов именно дисциплин антикриминальной направленности (Уголовно-исполнительное право, криминология, криминалистика и др.).

2. В связи с сокращением часов, которые даются на изучение трех дисциплин антикриминальной направленности, оставшихся в перечне общепрофессиональных, - уголовное право, уголовный процесс и криминалистика - необходимо пересмотреть или существенно совершенствовать саму методику преподавания вышеназванных предметов.

Оставляя за основу лекционные и практические занятия, следовало бы более активно использовать возможности современных научно-технических разработок в области электронного обучения[18], дистанционных образовательных технологий, обеспечить современными оперативно-техническими средствами криминалистическую лабораторию, криминалистический полигон, зал судебных заседаний, компьютерные классы, в том числе для осуществления процедур текущего контроля успеваемости и промежуточной аттестации обучающихся. Фонд оценочных средств должен соответствовать уровню сформированности всех компетенций, заявленных в образовательной программе.

3. В связи со значительным сокращением аудиторного времени на изучение дисциплин антикриминального блока, в том числе и уголовно-исполнительного права, следует шире использовать дополнительную и факультативную литературу, которая способна помочь обучающимся разобраться в содержании предмета. Такие категории уголовно-исполнительного права, как «тюремная и криминальная субкультура», «организованная преступность», «воры в законе», «тюремная стратификация» подробно рассматриваются в работах известных писателей и исследователей XIX и XX века[19].

Первым отечественным исследователем криминальной субкультуры можно по праву назвать Ф.М. Достоевского. В его повести «Записки из Мертвого дома», опубликованной в 1861 году, отражены впечатления пережитого и увиденного на каторге в Сибири, в Омском остроге, где он провел четыре года, осужденный по делу петрашевцев. Примерно в это же время в юридической литературе встречаются первые упоминания собственно об артелях воров и конокрадов. Криминальную

---

[18] Гармаев Ю.П. Проблемы и перспективы внедрения высоких технологий в криминалистические, межотраслевые средства противодействия преступности [Электронный ресурс]. - Режим доступа:
http://www.iuaj.net; http://crimpravo.ru/ru/blog/3093.html.

[19] Дорошевич В.М. Сахалин (Каторга). – М.: ООО «Изд-во Сова», 2009;Максимов С.В. Сибирь и каторга. – М.: ООО «Изд-во ЭКСМО Пресс», 2001; Солженицын А.И. Архипелаг ГУЛАГ. – М.: ИНКОМ НВ, 1991; Шаламов В.Т. Воспоминания. – М.: ООО «Изд-во Олимп», 2001; Чехов А.П. Остров Сахалин. – Правда, 1985; Губерман И. М. Прогулки вокруг барака. – М.: ООО «Глаголъ», 1993.

субкультуру описывал и А.П. Чехов в повести «Остров Сахалин». В.М. Дорошевич в своей работе «Сахалин (Каторга)» один из первых дает подробную и четкую криминологическую характеристику личности преступников, отбывающих наказание на каторге. Известный русский краевед и исследователь Сибири С.В. Максимов в работе «Сибирь и каторга» впервые пытается раскрыть имеющуюся стратификацию каторжан. Несомненно, в актив автора можно занести его попытку дать сравнительную характеристику словарю жаргонных слов и выражений, а также отдельно рассмотреть вопрос, посвященный «тюремной лирике».

Об особенностях советской уголовно-исполнительной системы периода культа личности Сталина писали А.И. Солженицын, В.Т. Шаламов. Мало кому известно, что поэт, песенник, бард Владимир Высоцкий тоже приложил усилие в раскрытии «лагерной» тематики. В соавторстве с журналистом Леонидом Мончинским был написан роман «Черная свеча» повествующий о проблеме выживания осужденных в заключении, о сложных взаимоотношениях между ними, и одним из первых обратившихся к теме «Воров в законе» (закрытую тогда тему). Роман в последствии (2006 г.) был экранизирован и на его основе был создан художественный фильм «Фартовый». И.М. Губерман – советский и израильский писатель, известный современному читателю и получивший широкую известность благодаря своим афористичным и сатирическим четверостишиям – «гарикам», после отбытия в советских лагерях издал документальную повесть «Прогулки вокруг барака». Отличительная черта в произведении И.М. Губермана это – тюремная стратификация осужденных в эпоху «застоя» советской пенитенциарной системы.

Как показывает опыт, перечисленные выше произведения авторов помогают точнее, рельефнее и четче рассмотреть изучаемые по дисциплине «Уголовно-исполнительное право» дефиниции и категории, и в конечном итоге освоить учебный курс.

4. Существенно скорректировать и прохождение практик (учебных, производственных и преддипломных) для студентов. Во-первых, пересмотреть сроки прохождения, составить более гибкий учебный план, сумев при этом развести учебные группы, курсы в течение всего учебного года. Во-вторых, требует доработки само содержание прохождения практики совместно с партнерами - будущими работодателями, учитывая при этом необходимость в практикантах и будущее их трудоустройство, расширив при этом возможности института общественных помощников в ряде правоохранительных органов[20]. Особого внимания требует преддипломная практика, проводимая для выполнения выпускных

[20] Хармаев Ю.В. К вопросу о получении специального образования сотрудниками правоохранительных органов // Подготовка кадров для силовых структур: современные направления и образовательные технологии // всероссийская научно-практическая конференция: 5-6 марта 2014. Иркутск: ФГКОУ ВПО «Восточно-Сибирский институт МВД России», С. 253.

квалификационных работ, тематика которых должна согласовываться (заказываться) с организациями. На наш взгляд, руководитель практики от организации мог бы выступить в качестве соруководителя (консультанта) дипломного проекта и принять участие в защите ВКР, что помогло бы преодолеть сложившийся разрыв в системе «наука-образование-практика»[21]. В этих же целях было бы целесообразно предусмотреть механизм прохождения стажировок, «семинаров», (курсов повышения квалификации) в правоохранительных органах преподавателями, ведущими специальные (антикриминальные) дисциплины.

4. Изучение криминалистики, основ оперативно-розыскной деятельности, уголовно-исполнительного права, криминологии в тесном взаимодействии с сотрудниками МВД, следственного управления следственного комитета, управлений федеральной службы исполнения наказаний, федеральной службы судебных приставов и др., у которых одним из критериев отчетности является взаимодействие с учебными подразделениями, общественностью и т.д. В распоряжении перечисленных правоохранительных государственных органов имеются криминалистические лаборатории, учебные центры, учебные классы, музеи, которые можно было бы использовать в учебном процессе в рамках взаимодействия и реализации имеющихся договоров о взаимном сотрудничестве.

6. В условиях реформирования важно не потерять накопившийся опыт организации научно-исследовательской работы студентов, в частности, традиции криминологической школы Бурятского госуниверситета[22]. Научные семинары, «круглые столы», конференции, симпозиумы и др. научно-практические мероприятия являются основным и важным элементом деятельности профессорско-преподавательского состава. Если в вузах нет серьезной науки, нет исследований, значит, далеки от нее и студенты. Эффективность противодействия преступности обеспечивается его последовательностью, нацеленностью на результат, и в том числе, высоким профессионализмом, опирающимся на научно обоснованный стратегический анализ криминальной и криминогенной ситуаций, учет результативности ранее принимавшихся мер[23].

---

[21] Хармаев Ю.В. ФЗ «О полиции» и современные проблемы ОВД //Вестник Бурятского государственного университета – 2014. – Вып. 2/2014. – С. 278-279.

[22] Раднаева Э.Л. Криминологические исследования в современной системе вузовской подготовки юристов // Преступность, ее виды и проблемы борьбы. Под общей редакцией А.И. Долговой. М., 2011. – С. 79-87.

[23] Обращение к Президенту Российской Федерации по результатам работы Всероссийской научно-практической конференции «Криминологическая ситуация в России, состояние реагирования и направления антикриминальной политики» российские криминологи приняли [Электронный ресурс]. -

7. Использование сетевой формы реализации программ бакалавриата, схем мобильности, совместных программ обучения через расширение сотрудничества образовательных учреждений и в т.ч. стран Арктического региона, что требует гармонизации учебных планов, внедрения европейской системы зачетных единиц трудоемкости дисциплин (ECTS) как средства академической мобильности студентов и в широком смысле проведения совместных прикладных исследований в образовательном праве.

Необходимо также иметь в виду, что уголовно-исполнительное право является составной частью уголовно-правового комплекса, в который наряду с данной отраслью права входят также уголовное и уголовно-процессуальное право[24]. Их нормы с разных позиций регулируют общественные отношения, возникающие в процессе и по поводу применения уголовного наказания. Так, если назначение наказания осуществляется в соответствии с нормами уголовного и уголовно-процессуального законодательства, то исполнение и отбывание наказания — в соответствии с нормами уголовно-исполнительного законодательства[25]. В свою очередь, освобождение от отбывания наказания регламентируется нормами трех отраслей права: уголовного, уголовно-процессуального и уголовно-исполнительного.

Полагаем, что вышеперечисленные предложения могут явиться залогом более эффективной подготовки юристов в новых условиях, тесного сотрудничества образовательных и научных учреждений, правоприменителей.

Литература:

1. Гармаев Ю.П. Проблемы и перспективы внедрения высоких технологий в криминалистические, межотраслевые средства противодействия преступности [Электронный ресурс]. - Режим доступа: http://www.iuaj.net; http://crimpravo.ru/ru/blog/3093.html.

2. Дорошевич В.М. Сахалин (Каторга). – М.: ООО «Изд-во Сова», 2009;Максимов С.В. Сибирь и каторга. – М.: ООО «Изд-во ЭКСМО Пресс», 2001; Солженицын А.И. Архипелаг ГУЛАГ. – М.: ИНКОМ НВ, 1991; Шаламов В.Т. Воспоминания. – М.: ООО «Изд-во Олимп», 2001; Чехов А.П. Остров Сахалин. – Правда, 1985; Губерман И. М. Прогулки вокруг барака. – М.: ООО «Глаголъ», 1993.

---

http://soprotivlenie.org/news/krupnym-planom/rossijskie-kriminologi-obratilis-k-prezidentu-rf-vladimiru-putinu/?print=print

[24] Шнайдер Г.Й. Криминология / Пер. с нем. М., 1994. С.408.

[25] Тарбагаев А.Н. Проблемы эффективности системы наказаний в российском уголовном праве // Криминологический журнал Байкальского государственного университета экономики и права. 2014. № 4. С.75-82.

3. Приказ Министерства образования и науки РФ от 04.05.2010, № 464 «Об утверждении и ведении в действие Федерального государственного образовательного стандарта высшего профессионального образования по направлению подготовки 030900 Юриспруденция (квалификация (степень) «бакалавр»).

4. Раднаева Э.Л. Криминологические исследования в современной системе вузовской подготовки юристов // Преступность, ее виды и проблемы борьбы. Под общей редакцией А.И. Долговой. М., 2011. – С. 79-87.

5. Хармаев Ю.В. К вопросу о получении специального образования сотрудниками правоохранительных органов // Подготовка кадров для силовых структур: современные направления и образовательные технологии // всероссийская научно-практическая конференция: 5-6 марта 2014. Иркутск: ФГКОУ ВПО «Восточно-Сибирский институт МВД России», С. 253.

6. Хармаев Ю.В. ФЗ «О полиции» и современные проблемы ОВД // Вестник Бурятского государственного университета – 2014. – Вып. 2/2014. – С. 278-279.

7. Обращение к Президенту Российской Федерации по результатам работы Всероссийской научно-практической конференции «Криминологическая ситуация в России, состояние реагирования и направления антикриминальной политики» российские криминологи приняли [Электронный ресурс]. - http://soprotivlenie.org/news/krupnym-planom/rossijskie-kriminologi-obratilis-k-prezidentu-rf-vladimiru-putinu/?print=print

8. Тарбагаев А.Н. Проблемы эффективности системы наказаний в российском уголовном праве // Криминологический журнал Байкальского государственного университета экономики и права. 2014. № 4. С.75-82.

9. Шнайдер Г.Й. Криминология / Пер. с нем. М., 1994. С.408.

Хамтын ажиллагаа

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУСГАЙЛСАН ЧИГ ҮҮРЭГТЭЙ БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

COOPERATION OF AGENCIES WITH SPECIFIC FUNCTIONS OF ENSURING NATIONAL SECURITY

Д.Гэрэлбаатар

Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага, стратегийн профессорын багийн ахлах багш, доктор, цагдаагийн хурандаа

Э.Анхбаяр

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны суралцагч, хошууч

Товч агуулга: Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын хамтын ажиллагааны эрх зүй үндсийг хилийн цэрэг, цагдаагийн байгууллагуудын жишээ нь дээр тодорхойлохыг зорилоо.

Abstract: *The objective is to identify, for example, the rights of cooperation between organizations that are specifically responsible for national security.*

Түлхүүр үгс: Хилийн цэрэг, Цагдаагийн байгууллага, хамтын ажиллагаа, харилцан ажиллагаа

Key words: *Border Patrol, Police, Cooperation and Cooperation*

Оршил

Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын үйл ажиллагааны эцсийн зорилго нь Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах гэж хэлэхэд маргах хүн үгүй байх. Тиймдээ ч үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоонд тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд буюу Байгаль орчныг хамгаалах алба, Гаалийн алба, Дипломат алба, Гамшгаас хамгаалах алба, Мэргэжлийн хяналтын алба, Зэвсэгт хүчин, бусад цэрэг, Татварын алба, Тусгай алба, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба, иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн алба, цагдаагийн алба гэсэн 11 алба хамаарч байна.

Даян дэлхийг түвшитгэн зассугай гэхүл

Даяар олон иргэнийг хураан эедүүлэгтүн

Дэлхийн хүмүүн олныг эедүүлье гэхүл

Далай их сэтгэл итгэлийг ологтун...

Чингис хааны сургаалиас

Хамтын ажиллагаа ба харилцан ажиллагаа

Хамтын ажиллагааг "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.1.1.2 дахь заалтад "Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах үндсэн арга нь улс төр, дипломатын үйл ажиллагаа байна. Энэ хүрээнд олон тулгуурт гадаад бодлогын зарчмыг эрхэмлэж, дэлхийн улс орнууд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ" гэж заасныг үндэслэн стратегийн буюу улс орны хэмжээнд явагдаж буй үйл ажиллагааг хэлнэ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7.2 дахь заалтад "Төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах үүрэгтэй" гэж заасан нь байгууллагуудын дунд болон доод түвшний үйл ажиллагааг **харилцан ажиллагаа** гэж болох юм.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй төрийн байгууллагууд нь хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулж, хамтран ажиллах үүрэгтэй.[1]

Харилцан ажиллагаа: Операцийн зорилгыг хангах эрх ашгийн үүднээс төрөл мэргэжлийн цэргийн салбар анги, нэгтгэлийн байлдааны журмын элемент, төрөл бүрийн зэвсгийн уялдуулан зохицуулсан хамтын ажиллагаа юм.

Монгол хэлний тайлбар тольд;**хамт** - цуг, ний; хамт явах; нэгэн хамт;

ажиллагаа - ажил, үйл, ажлын явц[2]

Англи хэлэнд;

Cooperation-ямар нэгэн зүйлд хүрэхийн тулд өөр компани, байгууллага, улс оронтой хамтран ажиллах үйл явц[3]

Cooperation-нэг зорилгод хүрэхийн тулд хамтран ажиллах үйл ажиллагаа эсвэл үйл явц[4] гэж тайлбарлажээ.

Улсын хил хамгаалах байгууллага энэ хуулийн 36.1-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд зэвсэгт хүчин, тагнуул, цагдаагийн болон холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллана.[5]

"Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах, буцаан өгөх хамтарсан комисс" /Оросын Холбооны Улстай хамтарсан гэрээ 2007 он/ гэрээнд хилийн цэрэг, цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах талаар тодорхой заасан ба тухайн орон нутгийн аймгийн Засаг даргын захирамжаар баталгаажуулдаг.

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн

этгээдийн туслалцаа, тэдний хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулна.[26]

Хил хамгаалах ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 01 дүгээр сарын 27-ны 02/28 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Хамтран ажиллах төлөвлөгөө" нь хамтран болон харилцан ажиллах баримт бичиг юм.



Харилцан ажиллагааг цар хүрээгээр нь:

- Опертив
- Тактик

Оперативын харилцан ажиллагаа нь операцын зорилгыг хангахын тулд опертивын нэг ба хэд хэдэн чиглэлд ажиллаж байгаа зэвсэгт хүчний томоохон бүлэглэлийн уялдуулан зохицуулсан хамтын ажиллагаа болно.

---

[1] Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. 2001 он.
[2] https://toli.query.mn/dictionary_items/1226
[3] https://dictionary.cambridge.org/dictionary/english/interaction
[4] https://languages.oup.com/google-dictionary-en/
[5] Хилийн тухай хууль. 2016 он. 36 дугаар зүйл.Төрийн мэдээлэл №7
[6] Цагдаагийн албаны тухай хууль. 2017 он. 64 дүгээр зүйл.Төрийн мэдээлэл №8

Тактикийн харилцан ажиллагаа нь цэргийн нэгтгэл, анги, салбаруудын хоорондын буюу зэргэлдээ нэгтгэл анги, салбар тэрчлэн ахлах захирагчийн хүч хэрэгсэлтэй уялдуулан зохицуулсан хамтын ажиллагаа

Харилцан ажиллагааг хэрэгжүүлэх зарчим нь:

- Идэвхтэй
- Тасралтгүй
- Харилцан хамааралтай
- Чиглэл зорилготой

хүч хэрэгслийн зориулалт, боломжийг тооцоолж иж бүрнээр ашиглах зэрэг болно.

Хилийн цэрэг ба цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны хэлбэр

Стратеги
-Хамтран ажиллах төлөвлөгөө, удирдамж, тушаал -Хамтарсан команд штабын дадлага сургууль зохион байгуулах -Мэдээ мэдээлэл солилцох -Онцгой нөхцөл үүссэн үед хамтарсан штаб томилох -Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан, эрэн сурвалжлагдаж буй иргэдийн талаар мэдээлэл солилцох г.мэт
Оператив
-Аймаг, орон нутгийн онцгой комисс, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Улсын хил хамгаалах туслах хүчний зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах -Харилцан ажиллах төлөвлөгөө боловсруулж мөрдөх -Улсын хил дээр гарсан гэмт хэргийн мэдээллийн дагуу, дуудлага мэдээлэл, өгөх -Онцгой нөхцлийн үед хамтран ажиллах -Хамтарсан оперативын сургалт, дадлага зохион байгуулах -Тусгай чиг үүргийн нэгжүүд хууль тогтоомжид заасан үүргийг хамтран хэрэгжүүлэх г.мэт
Тактик
-Гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл солилцох -Саатуулах, эхэн сурталжлагдаж байгаа иргэдийн талаар мэдээлэл өгөх -Хилийн бүс зурваст үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөх, эрэн хайх -Орон нутгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд оролцох -Гал түймрийн эрсдлийг бууруулах -Онцгой нөхцөл үүссэн үед гамшигийн хор хөнөөлийн бууруулах, аврах ажиллагааг зохион байгуулах -Гэмт хэрэгтнийг хилийн бүсэд эрэн хайх, саатуулах, баривчлах -Цэрэг тээврийн болон цуваанд үзлэг хийх -Байгаль хамгаалал, экологийн албаны чиглэлээр хамтран ажиллах г.мэт

Дүгнэлт

Дээрх холбогдох хууль, гэрээний дагуу тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг хилийн цэргийн анги, цагдаагийн байгууллагууд харилцан ажиллах төлөвлөгөөг баталгаажуулан, хамтарсан дадлагыг тогтмол үр дүнтэй зохион байгуулсанаас шалтгаалж, хилийн цагийн байдал болон гэмт хэрэг үүссэн үед хамтарсан ажиллагаа амжилттай явагдана гэж үзэж байна.

Ашигласан материалын жагсаалт

1. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. 2001 он
2. Хилийн тухай хууль. 2017 он
3. Цагдаагийн албаны тухай хууль 2017 он
4. Хил хамгаалах ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 01 дүгээр сарын 27-ны 02/28 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Хамтран ажиллах төлөвлөгөө"
5. https://dictionary.cambridge.org/dictionary/
6. https://languages.oup.com/

"Оюуны индэр" эрдэм шинжилгээний хурлын шилдэг илтгэлүүд

"ХОРИХ ЯЛААР ШИЙТГЭГДСЭН ӨСВӨР НАСНЫ ХОРИГДЛЫН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ"

"CONCERNING PROBLEMS THAT THE RIGHTS OF JUVENILE PRISONERS SENTENCED BY PRISON"



Б.Азжаргал
541 дүгээр дамжааны дэд түрүүч



Б.Булган
541 дүгээр дамжааны сонсогч

Товч агуулга: Өсвөр насны хүнд оногдуулах эрүүгийн хариуцлага, хорих ял эдэлж буй өсвөр насны хоригдолд ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг эрэлхийлэхэд оршино.

Abstract: *It is to study the issues that arise in the process of criminal liability for juvenile prisoners who are serving prison terms.*

Түлхүүр үг: Ял, өсвөр насны хоригдол, хорих ял,

Keywords: *Penalty, juvenile prisoner, imprisonment*

Хүн төрсөн цагаасаа эхлэн бүхэл амьдралынхаа туршид бие махбод, сэтгэл зүйн хувьд хувьсан өөрчлөгдөж байдаг бөгөөд хамгийн их өөрчлөгддөг эмзэг үе нь өсвөр нас байдаг билээ. Энэхүү өсвөр насны өөрчлөлтийн үед хүүхэд[27] нь хоёр том асуудалтай тулгардаг. Үүнд:

[27] Хүүхдийн Эрхийн конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "18 наснаас өмнө насанд хүрсэнд тооцогдоогүй бол 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд" гэнэ.

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хорих: Өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын нөхцөлийг хуулиар тогтооно. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа өсвөр насны хүнд ерөнхий, мэргэжлийн боловсрол, хөдөлмөрлөх, амьдрах ухааны дадал олгох сургалт зохион байгуулна. Хорих ял эдэлж байгаа өсвөр насны хүнээр хөдөлмөр эрхлүүлэхгүй. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял эдэлж байсан өсвөр насны хүн арван найман насанд /18/ хүрсэн бол түүний эдлээгүй үлдсэн хорих ялыг хорин нэгэн нас /21/ хүртэл сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад үргэлжлүүлэн эдлүүлэх, эсхүл насанд хүрэгчдийн хорих байгууллагад шилжүүлэн эдлүүлэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ: Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэж болно. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

Гэмт хэрэгт холбогдсон нийт яллагдагчдын тоо 2022 оны 1 дүгээр сард 1435 болж, өмнөх оны мөн үеэс 763 (2.1 дахин)-аар өсжээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 45 (3.1%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 170 (11.8%) нь эмэгтэйчүүд байна.[29] (Хавсралт№2-аас үзнэ үү). Жилээс жилд 18 хүртэлх насны хүүхэд гэмт хэрэгт холбогдох нь ихэсч байгаа бөгөөд үүнээс гэмт хэрэгт холбогдсон энэ насны хүүхдүүдийн үйлдсэн гэмт хэргийн шинж байдлаас хамааран эрүүгийн хариуцлагыг оногдуулж байна.

Өсвөр насны хүнд ихэвчлэн хорихоос өөр төрлийн ял болон тэнсэх, ял хойшлуулах арга хэмжээг авдаг болович үйлдсэн гэмт хэргийн шинж байдлаас хамааран зарим тохиолдолд хорих ял оногдуулахаар хуульчилсан байдаг.

2022 оны байдлаар хорих ялаар шийтгэгдсэн өсвөр насны хоригдлуудыг гэмт хэргийн зүйлчлэлээр нь судлан авч үзвэл ЭХТА-д заасан 10.1-д заасан гэмт хэрэгт ял шийтгүүлсэн 1, 11.1-д заасан гэмт хэрэгт ял шийтгүүлсэн 2, 12.1-д заасан гэмт хэрэгт ял шийтгүүлсэн 24, 17.1-д заасан гэмт хэрэгт шийтгүүлсэн 6, 17.2-д заасан гэмт хэрэгт ял шийтгүүлсэн 3, нийт 36 хоригдол ШШГЕГ-ын харъяа Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байна. (Хавсралт№3-аас үзнэ үү)

1966 оны БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуульд анх Хүмүүжил-Хөдөлмөрийн колонид 18 нас хүрээгүй хоригдлыг хүмүүжүүлнэ гэж заасан бөгөөд энэ нь өсвөр насны хүнд оногдуулж буй ялыг эдлүүлэх нөхцөл журмыг тусгайлан заасны хэлбэр юм. Ийнхүү хуулийн

[29]https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=4.%20Crime%202022%20I%20mgl.pdf&ln=Mn

шинэчлэлийн хүрээнд Хүүхдийн хорих 411 дүгээр анги нь Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага хэмээн нэршлийн болон чиг үүргийн хувьд өөрчлөгдсөн. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын нэг онцлог нь тусгай сургуультай, хоригдол хүүхдүүдэд ЕБС-ийн хөтөлбөрөөр хичээл зааж, боловсрол эзэмшүүлдэг.

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага нь нэг талаас ШШГБайгууллага буюу хорих байгууллага, нөгөө талаас Боловсрол, шинжлэх ухааны яамны харъяа Нийслэлийн ерөнхий боловсролын 110 дугаар сургууль гэсэн хоёр өөр чиг үүрэг бүхий байгууллагын нэгдэл юм. Энэхүү байгууллага нь ерөнхий боловсролын мэдлэг олгож, өсвөр насны хоригдлуудыг сурган хүмүүжүүлэх замаар нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиг үүргээ давамгайлан биелүүлэх шаардлагатай. Гэтэл одоогийн сургалт хүмүүжлийн тусгай байгууллага нь хорих ангийн нэгэн адил хууль, дүрэм журмын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Үүний дагуу хорих ял эдлүүлж буй нөхцөл байдал нь бусад хорих ангиас ялгарах зүйлгүй байна. Сурган хүмүүжүүлэх тусгай байгууллага гэдэг үг зүйн утгаараа хорих ял эдэлж буй өсвөр насны хоригдлуудад хорих ангид хоригдож буй мэт мэдрэмж төрүүлэхгүй байх нь чухал шаардлагатай. Хорих ангид байгаа мэт мэдрэмж төрүүлж байгаа нь насанд хүрсэн хүн, өсвөр насны хүн хоёрын ял эдлүүлэхэд ялгаатай ойлголт байхгүй байна.

Мөн энэ байгууллагын үйл ажиллагаа явуулж буй байр нь ашиглалтын шаардлага хангахгүйн улмаас хүний эрх тэр дундаа хүүхдийн эрх зөрчигдөх нөхцөл үүсээд байна. Тухайлбал, тус байрны хана цуурсан, нурсан, суулт өгсөн, газрын гадаргын ус ихтэй, хөрсний хөлдөлт явагддаг тул засвар хийгээд нэмэргүй нөхцөлд байна. Ийм орчин нөхцөлд хүмүүжиж байгаа хүүхдүүд болон тус байгууллагын ажилтан албан хаагчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх эрх зөрчигдөж байна. Цаашлаад энэ байдал хоол хүнс болон агааржуулалт зэрэгт нөлөөлөх эрсдэлтэй билээ.

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын одоо ашиглаж буй гурван барилга нь 1978 онд цэргийн казармын зориулалтаар ашиглалтад оржээ. 40 гаруй жилийг элээсэн тус барилгуудыг хорих 431 дүгээр анги ашиглаж байсан бөгөөд 2012 онд мэргэжлийн хяналтын байцаагчийн 07-208/638, 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 02-03-084/818 тоот дугаартай дүгнэлтээр хүн ажиллаж, амьдрах боломжгүй, ашиглалтыг зогсоох тухай дүгнэлтүүд ирүүлж байсан. Гэтэл нурах шахсан өнөө барилгуудыг 2017 оны Засгийн газар, ШШГЕГ-ын шийдвэрээр Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад шилжүүлэн өгч, нүүж орсон.

Улмаар нөхцөл байдал хүндэрч 2020 оны наймдугаар сард Налайх, Багахангай дүүргийн прокурорын газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газартай хамтран өсвөр насны хоригдлуудын сурдаг, амьдардаг байруудыг нарийвчлан шалгасан. Гэтэл тус хорих ангийн барилгууд нь

1. Би үзэл баримтлал- Үе тэнгийнхнийхээ дунд зохих байр суурь эзлэх, нэр хүндтэй байх, нэг талаас бусадтай адил байх, нөгөө талаас тэд нараас ялгарах хүсэл тэмүүлэл, түүгээрээ гайхуулах, бахархах хандлага.

2. Эцэг эх, асран хамгаалагчаас хараат бус байх- Өөрийгөө том хүн боллоо хэмээн бодож, насанд хүрсэн хүний байр сууринаас аливаад хандахыг хичээдэг. Үүнээсээ болон эцэг эхтэйгээ зөрчилддөг.

Дээрх 2 асуудлаас үүдэлтэйгээр өсвөр насны хүүхэд гэмт хэрэгт холбогдох, гэмт хэрэг үйлдэж, нийгэм болон хүнд хор хохирол учруулах эрсдэлийг бий болгож байдаг.

Нөгөөтэйгээр сүүлийн жилүүдэд манай улсад нийгмийн сөрөг хүчин зүйлүүд болох ажилгүйдэл, архидалт, гэр бүл салалт, эцэг, эхийн хараа хяналтгүй болон хохирогчдын биеэ хамгаалах чадваргүй байдал нь гэмт хэрэг гарахад нөлөөлж байгаа үндсэн шалтгаан болж байна. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял эдэлж буй өсвөр насны хоригдлуудын гэр бүлийн байдлыг авч үзвэл, бүтэн өнчин-3, өргөмөл-1, хагас өнчин-8, хойд эцэг эхтэй-4, эцэг эх салсан-4, төрсөн эцэг эхтэй-16 хоригдол байна. (хавсралтаас №1-ээс үзнэ үү). Үүнээс үзэхэд нийт ял эдэлж байгаа хоригдлуудын 55.6 хувь нь ар гэрийн асуудалтай байгаа нь гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн байж болзошгүй нь харагдаж байна.

Монгол улс 1960 онд НҮБ-д нэгдэн орж, Олон улсын гэрээ конвенцид заасан дүрэм журмын дагуу аливаа үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээснийхээ хүрээнд 1990 онд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн конвенцид нэгдэн орсон байдаг. Тус конвенцийн 37-р зүйлд зааснаар:

Оролцогч улсууд нь:

(a) хүүхдэд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхгүй байх, 18 насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэрэгт цаазаар авах буюу суллах боломжгүйгээр бүх насаар нь хорих ял оногдуулахгүй байх;

(b) хүүхдийн эрх чөлөөг хууль бусаар буюу дур мэдэн хязгаарлаж болохгүй. Хүүхдийг баривчлах, саатуулах, хорих арга хэмжээг хамгийн богино тохиромжтой хугацаанд эцсийн арга хэмжээ болгон хэрэглэх;

(c) эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүрд насных нь хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг харгалзан нэр төрийг нь хүндэтгэн, хүнлэг хандана. Дээд ашиг сонирхолд нь харшилна гэж үзээгүй бол эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүрийг насанд хүрэгчдээс тусгаарлах, онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд гэр бүлтэйгээ харилцаатай байх, уулзах боломжоор хангах;

(d) эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүр эрх зүйн болон бусад зохих туслалцааг даруй авах, түүнчлэн эрх чөлөөгөө хасуулсан нь хуулийн үндэслэлтэй эсэхийг шүүх буюу эрх бүхий хараат бус, аль нэг талын эрх

ашигт үйлчлэхгүй байгууллагаар тогтоолгох, шуурхай шийдвэрлүүлэх эрхтэй.

Манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулинд гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнд Эрүүгийн хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ [28] гэж хуульчилсан байдаг.

Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан ял оногдуулж, оногдуулсан ял дээр нэмж, эсхүл ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.



Нийтэд тустай ажил хийлгэх ял: Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд харшлахгүй нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулна. Шүүх өсвөр насны хүнд нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт гурваас дээшгүй цагаар, нийт нэг зуун хориос гурван зуун жаран цагаар тогтооно.

Зорчих эрхийг хязгаарлах ял:Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд зорчих эрхийг хязгаарлах ял 120-360 цаг оногдуулна.

[28] Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2016. №07

бүхэлдээ хэзээ мөдгүй нурах бүх "болзол"-ыг хангасан болох нь дахин тогтоогдсон байна.

Тухайлбал, хоригдлын I байр буюу Ерөнхий боловсролын 110 дугаар сургуулийн байр, II байр буюу гал тогоо, халуус ус, ариун цэврийн өрөө, аж ахуйн хоригдлын байр, III байр буюу авто гражад шалгалт хийхэд дээрх барилгуудын үндсэн хийцэд их хэмжээний эвдрэл, гэмтэл гарсан, хөрсний овойлт, суултаас шалтгаалан нэгдүгээр давхрын шал нь хотойж суулт өгсөн, бетон хаяавчнууд нь хагарсан, агааржуулалтын хоолойнууд нь бөглөрсөн, гадна дотор хананд их хэмжээний нэвт хагарал цууралт, суулт өгсөн, хөрсний ус их хэмжээгээр нэвчдэг болсон нь тогтоогдсон. Мөн хамгийн ноцтой нь тус барилга газар хөдлөлтийн чичирхийлэл болон механик үйлчлэл буюу доргилтод бүхэлдээ нурах нөхцөл бүрдсэн байгааг тогтоосон байна.

Өсвөр насны хоригдлууд хэзээ мөдгүй нурах шахсан барилгад хоригдож байгаа нь Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т заасан Монгол улсын иргэн "Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй", Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 209 дүгээр зүйлд заасан "Хорих өрөө нь олон улсын стандартад нийцсэн байх" шаардлага хангахгүй, НҮБ-ын 1955 оны I их хурлаар батлагдсан "Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд"-ийн 10, 11 дүгээр зүйлүүдийг тус тус зөрчсөн буюу өсвөр насны хоригдлуудын эрх ноцтой зөрчигдсөөр байна.

Хэдийгээр гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлж олон нийтээс тодорхой хугацаагаар тусгаарлагдаж, чөлөөтэй зорчих эрх нь хязгаарлагдаж буй хэдий ч тэдгээр өсвөр насны хүүхдүүдийн Монгол улсын Үндсэн хуульд заасан бусад эрх ямар нэгэн байдлаар зөрчигдөх ёсгүй билээ.

Мөн хууль тогтоомжийн уялдаа холбоо муу байгаагаас хүүхдийн эрх зөрчигдөж байгаа асуудлыг анхаарах шаардлагатай байна. Хорих ангийн дотоод журам, бусад эрх зүйн актуудыг Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэхэд зарим талаар эрх зүйн хийдэл гарч, практик нөхцөл байдалтай зөрчилддөг. Тухайлбал, Хорих ангийн дотоод журмын 7 дугаар зүйлд заасан Хоригдолд зөвшөөрөгдөх эд зүйлсийн жагсаалтад ЕБС-д суралцаж буй хоригдлын хичээл хийхтэй холбоотой хичээлийн хэрэглэгдэхүүн бусад шаардлагатай зүйлсүүдийг тусгайлан тусгаж өгөөгүй нь энэ журмыг зөрчих үндэслэл болж байна.

Мөн ШШГТХуулийн 239 дүгээр зүйлд зааснаар нээлттэй хорих ангид хоригдож буй хоригдолд тодорхой нөхцөл, шалтгаан үүссэний улмаас 7 хүртэлх хоногийн чөлөө олгож болох тухай хуульчилсан байдаг. Гэтэл Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага нь хорих ангийн адил дэглэм, зэрэглэлээр хуваагддаггүй тул өсвөр насны хоригдлуудад

зайлшгүй шаардлагатай тодорхой нөхцөл байдал үүссэн бол чөлөө олгох талаар ямар нэгэн хуулийн зохицуулалт байхгүй байна.

Хорих ял эдэлж буй өсвөр насны хоригдлуудын гэр бүлийн байдал тогтворгүй, анхаарал халамж сул, амьжиргааны түвшин доогуур зэрэг нөхцөл байдлаас шалтгаалж өсвөр насны хоригдлуудад сурагчийн хувцас, хичээлийн хэрэгслийг авч өгөх боломжгүй тул сурагчийн дүрэмт хувцас, хичээлийн хэрэгсэл, сурах бичгийг хамтран ажилладаг төрийн бус байгууллага болон сайн үйлсийн тусламж хандиваар шийдвэрлэдэг.

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хоригдож ял эдэлж байгаа боловч нөгөөтэйгүүр боловсрол эзэмшиж нийгэмшиж байгаа сурагч тул Хоригдол гэсэн нэр томьёо нь утга агуулгын хувьд ч оновчгүй нэршил юм.

Дүгнэлт, санал

Өсвөр насны хүнд оногдуулсан хорих ял эдлүүлэх ажиллагаа нь бусад төрлийн ял эдлүүлэх ажиллагаанаас илүү онцлогтой юм. Учир нь аливаа хүн өсвөр насандаа цаашдын амьдралын төлөвшлийг олж авдаг бөгөөд ял эдэлж буй өсвөр насны хоригдлуудын хувьд дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх зөв үзэл хандлагыг төлөвшүүлэх нь нэн чухал.

Мөн өсвөр насны хүнд оногдуулсан хорих ял эдлүүлэх ажиллагаа нь уян хатан, хүний эрхийн мэдрэмжтэй байхыг шаарддаг тул төрөөс энэ төрлийн ажиллагаанд ихээхэн анхаарч, хууль эрх зүн орчин бүрдүүлэх шаардлагатай байна.

Дээрх илтгэлтэй холбогдуулан дараах саналыг дэвшүүлж байна.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

- Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад мөрдөх дотоод журмыг тусгайлан тогтоох
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өсвөр насны хоригдлын чөлөө олгох асуудлыг тодорхой тусгах

Төсөв, санхүүгийн чиглэлээр:

- Хичээлийн сурах бичиг, сурагчийн дүрэмт хувцас, хичээлийн хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авах зардлыг улсын төсөвт жил бүр суулгах

Барилга байгууламжийн талаар:

- Цэвэр, бохир, дулааны шугамд холбогдсон байршилд шинэ барилга байгууламж барих (Хорих ангийн өрөөний стандартаар бус бусад ЕБС-ийн жишгээр адил зохион байгуулалттай байх)
- Сургалтын анги танхимын хүрэлцээг нэмэгдүүлэх
- Сургуулийн бүс, хоригдлын амьдралын бүсээр ялган зааглах

Хавсралт №1



Хавсралт №2



Хавсралт №3


Гэр бүлийн байдлаар нь:
18
16
14
12
10
8
6
4
2
0
Бүтэн өнчин
Өргөмөл
Хагас өнчин
Хойд эцэг эхтэй
Эцэг эх салсан
Төрсөн эцэг эхтэй
Series 1
3
1
8
4
4
16

Ашигласан материалын жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 1992. №01
2. Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2002. №05
3. Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2016. №07
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2017. №24
5. С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги УБ., 2002 он
6. Ч.Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай. УБ., 2021 он
7. Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2012 он
8. https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=4.%20Crime%202022%20I%20mgl.pdf&ln=Mn
9. www.1212,mn
10. https://www.ulsturch.mn/article/52302
11. НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц
12. https://blog.ipleaders.in/procedure-in-relation-to-children-in-conflict-with-law-under-the-juvenile-justice-act/
13. https://archive.crin.org/en/home/ages/asia.html